



Тусгай шилжүүлгийн байгууллагуудад Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр төсөвлөсөн урамшууллын дүнг хасч тооцоолсноор 808.1 сая төгрөгийн цалингийн сангийн өр үүсэх тооцоолол гарч байна.

**Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц**

2018 он

Уг тайланг [WWW.AUDIT.MN](http://WWW.AUDIT.MN) сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дү гнэлттэй дахь холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл багийн байвал 99014227, 96 884510 ордон дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймаг Төрийн Аудитын газар Улиастай сум, Жинст Нутгийн захиргааны 309, 310 тоот өрөө

**Гүйцэтгэсэн:**

Ахлах аудитор  
Б.Дагвасүрэн

Аудитор Г.Заяа

**Хянасан:**  
Дарга, Тэргүүлэх аудитор Л.Уламбаяр

Аудитын менежер  
Г.Хашцэцэг

2018.10.31

<p><i>Тайланг хянасан:</i>  <i>Завхан аймаг дахь Төрийн аудитын газар</i></p> <p><i>Дарга дарга, Тэргүүлэх аудитор:</i>  <i>Л.Уламбаяр</i></p> <p><i>Аудитын менежер:</i>  <i>Г.Хашцэцэг</i></p> <p><i>Тайланг бэлтгэсэн:</i></p> <p><i>Ахлах аудитор:</i>  <i>Б.Дагвасүрэн</i></p> <p><i>Аудитор:</i>  <i>Г.Заяа</i></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99014227, 98664510 дугаарын утсаар харилцана уу.</i></p> <p><b>ХАЯГ:</b>  <i>Завхан аймаг дахь Төрийн аудитын газар.</i>  <i>Нутгийн удирдлагын ордон</i>  <i>Өрөө №309,310</i></p>	<p><b>АГУУЛГА</b></p> <p><b>АУДИТЫН ТАЙЛАН</b></p> <p>Аудит хийсэн үндэслэл, хугацаа, зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Аудитын дүн <span style="float: right;">3</span></p> <p>Бүлэг 1. 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх</p> <p>Бүлэг 2. 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх</p> <p>Бүлэг 3. 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу , үр дүнтэй зарцуулж буй эсэх</p> <p>Зорилт 4. ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх</p> <p>Дүгнэлт <span style="float: right;">34</span></p> <p>Зөвлөмж <span style="float: right;">35</span></p> <p>Тайлан баталгаажуулсан тушаал <span style="float: right;">36</span></p> <p>Хавсралт судалгаа</p>
--	--

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОН	Орон нутаг
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан соёлын яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
САД	Санхүүгийн албаны дарга
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/125 тоот туушаалаар батлагдсан ҮАГ-ын 2018 онд аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Завхан аймгийн Төрийн аудитын газар хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган ҮАГ-т хүргүүлж нэгтгүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зоилтуудыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэв. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд хийцсэн эсэх

### Хамарсан хүрээ

Завхан аймгийн ИТХ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх ХБТХ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны эхний 9 сарын санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль
- ❖ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- ❖ Татварын багц хуулиуд
- ❖ Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд

- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж

**Аудит хийсэн хугацаа:**

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 03-наас эхэлж 11-р сарын 05-нд дуусгав.

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Дарга, тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Хашцэцэг хэрэгжүүлж Ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Заяа нар гүйцэтгэв.

## АУДИТЫН ДҮН

**Бүлэг.1 ТЕЗ-ийн 2018 оны төсөв бодит байдалтай уялдаагүй СЯ-ны хянасан төсөвт баригдсан хүрэлцээ муутай төсөв батлагдсан байна.**

**1.1. 2018 оны нэгдсэн төсөв ТЕЗ-ийн төсвийн хүрээний мэдэгдлүүдийн үзүүлэлтүүд нь төсвийн тогтвортой байдлын тухай ,төсвийн тухай хуулийн шаардлагуудад нийцэж байна.**

## ОНТО

Аймгийн татварын хэлтэс нь Монгол Улсын Сангийн Яаманд 2013-2016 онуудын орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл, 2017 оны ХБГ болон нийт орлого, ХБГ хянаснаар, 2018 оны татварын орлогын төлөвлөгөө, 2019-2020 оны орон нутгийн татварын орлогын төсөөлөл, тооцоо судалгааг хийж хүргүүлсэн байна.

Төсөөллүүдийг хянаж үзэхэд 2018 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 2017 оны гүйцэтгэлээс 79.9 сая төгрөг буюу 1% -иар нэмэгдүүлэн баталж, 2019-2020 онуудын төсөөллүүд 1-2%-иар бууруулан төсөөлөгдсөн байна.

Хүснэгт-1 / сая-төгрөгөөр/

**Орон нутгийн татварын орлогын 2017-2020 оны төсөөлөл буюу 2018 оны хянагдаж батлагдсан орлого**

Он	2017 он		2018 он			2019 он санал	2020 он санал	2018 он батлагдсан төлөвлөгөө
	ХБГ хянасан	Нийт орлого/санал	үүнээс: суурь орлого	хянасан нийт орлого СЯ	үүнээс: суурь орлого			
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>9201.7</b>	<b>7374.3</b>	<b>7387.0</b>	<b>9120.2</b>	<b>9099.3</b>	<b>9039.1</b>	<b>8872.1</b>	<b>9121.8</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО</b>	<b>7142.4</b>	<b>5580.3</b>	<b>5563.0</b>	<b>7049.5</b>	<b>7028.7</b>	<b>6734.1</b>	<b>6579.5</b>	<b>7051.1</b>
<b>1. ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>6787.4</b>	<b>5280.3</b>	<b>5263.0</b>	<b>6677.5</b>	<b>6656.7</b>	<b>6351.1</b>	<b>6186.5</b>	<b>6677.5</b>
1.1 Орлогын албан татвар	5421.9	4377.3	4377.3	5437.5	5437.5	5016.1	4819.0	5437.5
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	6326.5	5377.3	5377.3	6267.5	6267.5	5816.1	5619.0	6267.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	5262.3	4900.0	4900.0	5257.5	5257.5	5333.6	5120.0	5257.5
Үйл ажиллагааны орлогын албан татвар	200.0	36.5	36.5	130.0	130.0	38.5	39.0	130.0
Хөрөнгийн орлого/хүүгийн орлого/ Шууд бус орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	864.2	440.8	440.8	880.0	880.0	444.0	460.0	880.0
1.2 Хөрөнгийн орлого	904.7	1000.0	1000.0	830.0	830.0	800.0	800.0	830.0
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	431.0	371.0	353.7	439.5	418.6	450.0	450.0	439.5
Бууны албан татвар	122.0	110.0	110.0	125.0	125.0	130.0	130.0	125.0
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	49.0	41.0	41.0	49.5	49.5	50.0	50.0	49.5
	260.0	220.0	202.7	265.0	244.1	270.0	270.0	265.0

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

1.3 Бусад татвар,төлбөр хураамж	934.5	532.0	532.0	800.5	800.5	885.0	917.5	800.5
1.3.1Бусад нийтлэг төлбөр хураамж	298.0	209.4	209.4	304.0	304.0	313.0	330.0	304.0
Улсын тэмдэгтийн хураамж	195.0	120.0	120.0	197.0	197.0	200.0	210.0	197.0
Тигээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	13.0	9.4	9.4	15.0	15.0	18.0	20.0	15.0
Хог хаягдлын йлчилгээний хураамж	90.0	80.0	80.0	92.0	92.0	95.0	100.0	92.0
1.3.2 Газрын төлбөр	186.0	148.2	148.2	190.0	190.0	195.0	200.0	190.0
Үүнээс Газрын төлбөр	186.0	148.2	148.3	190.0	190.0	195.0	200.0	190.0
1.3.3 Байгалийн ургамлын нєєц ашигласны төлбөр	450.5	174.4	174.4	306.5	306.5	377.0	387.5	306.5
ҮүнээсОйн нєєц ашигласны төлбөр	195.0	80.0	80.0	100.0	100.0	110.0	120.0	100.0
Ус, рашааны нєєц ашигласны төлбөр	250.0	90.0	90.0	200.0	200.0	260.0	260.0	200.0
Байгалийн ургамлын нєєц ашигласны төлбөр	5.5	4.4	4.4	6.5	6.5	7.0	7.5	6.5
<b>2. ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>355.0</b>	<b>300.0</b>	<b>300.0</b>	<b>372.0</b>	<b>372.0</b>	<b>383.0</b>	<b>393.0</b>	<b>373.6</b>
Хii торгуулийн орлого	55.0	20.0	20.0	60.0	60.0	65.0	70.0	60.0
Төсвийн байгууллагын өөрийн орлого	0.0	0.0	0.0	7.0	7.0	8.0	8.0	8.6
Нэр заагдаагй орлого	300.0	280.0	280.0	305.0	305.0	310.0	315.0	305.0
3. Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлалын орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	<b>2059.3</b>	<b>1794.0</b>	<b>1824.0</b>	<b>2070.7</b>	<b>2070.7</b>	<b>2305.0</b>	<b>2292.6</b>	<b>2070.7</b>
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	130.0	130.0	130.0	131.0	131.0	140.0	133.0	131.0
НӨАТатвар	540.0	540.0	540.0	540.0	540.0	560.0	560.0	540.0
Онцгой албан татвар	75.0	70.0	70.0	75.0	75.0	80.0	74.0	75.0
Ашигт малтмалын нєєц ашигласны төлбөр	1289.7	1030.0	1060.0	1300.0	1300.0	1500.0	1500.0	1300.0
Агаарын бохирдлын төлбөр	24.7	24.0	24.0	24.7	24.7	25.0	25.6	24.7

2018 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг Сангийн яам батлахдаа 2014-2017 онуудын татварын орлогын гүйцэтгэл, 2018 оны орон нутгийн орлогын төсвийн санал болон эдийн засгийн өсөлт бууралт, татварын суурь орлогуудын тооцоололд хянаж баталсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөг батлахдаа дараах татваруудыг харгалзан баталсан байна.Үүнд:

- Нэг удаагийн татварын орлогыг хасч
- Татварын хуулийн өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн байна.

Аймгийн татварын хэлтэс нь 14 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн 2018 оны орлогын төсөөллийг явуулсан бөгөөд татварын нэр төрлөөр орлого нэмэгдүүлэх эсвэл бууруулах талаар ямар нэгэн тооцоолол санал хүргэгдээгүй байна.

**ЕБС-Аймгийн 29 ЕБС -иуд 2016 - 2017 оны төсвийн гүйцэтгэл болон ХБГ-д үндэслэн 2018 оны төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллүүдийг хийж холбогдох газарт хүргүүлсэн байна.**

2018 оны төсвийн төсөл нь 2017 оны ХБГ-ээс 22.8%-иар өссөн, 2019-2020 онуудын төсөөлөл 2018 оны төсөөллөөс 0.1%-иар бууруулан төсөөлсөн./хавсралт-1-ЕБС/

**СӨБ-** Аймагт улсын 36, хувийн 3 нийт 39 цэцэрлэгүүд 2016 - 2017 оны гүйцэтгэл болон ХБГ-д үндэслэн 2018 оны төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллүүдийг хийж холбогдох газарт хүргүүлсэн байна

2018 оны төсвийн төсөл нь 2017 оны ХБГ-ээс 33%-иар өссөн, 2019-2020 онуудын төсөөлөл 2018 оны төсөөллөөс 9.9%-иар нэмэгдүүлэн төсөөлсөн./Хавсралт-2-СӨБ/

**ЭМТ-** Тусгай шилжүүлгийн 19 сумын эрүүл мэндийн төв, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, 2017 оны батлагдсан төсөв, ХБГ, 2018-2020 төсвийн төсөөллүүдийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, Эрүүл мэндийн яам дээрх төсөөлөл, төслүүдийг Сангийн яаманд хянуулан батлуулсан байна./хавсралт-3-ЭМТ/

2018 оны төсвийн төсөл нь 2017 оны ХБГ-ээс 16.3%-иар өсөн, 2019-2020 онуудын төсөөлөл 2018 оны төсөөллөөс 21.2%-иар нэмэгдүүлэн төсөөлсөн./Хавсралт-2-СӨБ/,

Нутгийн захиргааны байгууллагууд, тусгай шилжүүлгийн байгууллагуудын 2018 оны төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллүүд нь цалингийн зардал, нэмэгдэл урамшууллуудыг 20-45% хүртэл нэмэгдүүлсэн, өндөр тооцсон тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмжүүдээр өсч буурсан, мөн ЕБС, СӨБ-дийн хувьд хүүхдийн тооноос шалтгаалан өсгөж, бууруулсан өөдрөг төсөөллүүд болжээ.

Нутгийн захиргааны байгууллагууд Төсвийн хүрээний мэдэгдлүүдийг санхүүгийн албаны дарга нарт нэгтгүүлж, САД нар нь төсвийн төлөвлөлтийн программд шивж аймгийн Санхүү төрийн сангийн төсвийн мэргэжилтэнд хүргүүлж, төсвийн мэргэжилтэн нэгдсэн дүнг Сангийн яаманд, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд тухайн салбаруудын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнд нэгтгүүлэн нэгтгэлийг төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнгүүд ТЕЗ-д нэгтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.2, 8.4.3 дугаар заалтууд, орон нутгийн суурь төсвийн санал боловсруулах цагалбарын 4 дүгээр зүйлийн 4.3.1, 4.3.2, 4.3.3 дугаар заалтуудын хугацаанд нь өргөн мэдүүлжээ.

ТЕЗ-ийн төсвийн хүрээний мэдэгдлүүдийн үзүүлэлтүүд нь төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн тухай хуулийн шаардлагуудад нийцэж байна гэж дүгнэж байна.

Төсвийн төслийг нэгжээс шат шатны салбар, ТЕЗ-д албан томилолтын зардал гарган ирж очиж нэгтгүүлдэгч дороос гаргасан төсвийн ач холбогдол бага 2018 оны төсөв СЯ-ны хянасан суурь үзүүлэлт, хянаж баталсан төсвийн хязгаарт баригдсан байна.

Энэ нь 2017-2018 оныг дуустал төсвийн хэмнэлтэнд шилжих МУ-ын Их хурал, СЯ-аас гаргасан тогтоол, заавар журам нөлөөлж байна гэж үзэж байна.

**Аймгийн ИТХ-ын 30 дугаар тогтоолоор халамжийн сангийн зарлагыг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, байгууллагуудын төсвийг батлахдаа халамжийн сангийн Сангийн яамны хянаж баталсан төлөвлөгөөнөөс 820.7 сая төгрөгийг гүйлгэн зарцуулахаар баталжээ.**



**Орон нутгийн орлого, суурь зарлагын төлөвлөлтийн талаар:** УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар орон нутгийн 2018 онд төвлөрүүлэх орлогыг 7881.1 сая төгрөгөөр баталсан байна. /хувь хүний орлогын албан татварын буцаан олголт орсон/

Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ны өдрийн хуралдааны 30 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 6267.5 сая, татварын бус орлогыг 372.0 сая, хөрөнгийн албан татвар 439.5 сая, бусад албан татвар 1050.5 сая төгрөгөөр, аймгийн дүнгээр нийт 8129.5 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянасанаас 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь Төрийн аудитын байгууллагаас аймгийн орон нутгийн орлогыг нэмэгдүүлэхээр оруулсан 58.0 сая төгрөгийн санал, аймгийн ИТХ-ын хуралдаанаар 192.0 сая төгрөгөөр нийт 250.0 сая нэмэгдүүлэн баталсан дүн байна /төсөвт байгууллагын өөрийн орлого 8.6 сая төгрөг орсон/. Үүнд:

Хүснэгт-2 /сая.төг-р/

Татварын нэр төрөл	2017 оны СЯ-ны хянасан суурь	Аймаг, сумын ИТХ-ын анх баталсан дүн	Зөрүү
Нийт орлогын дүн	7879.5	8129.5	250.0
Татварын орлогын дүн	6267,5	6267.5	-
<b>Хөрөнгийн албан татвар</b>	439.5	439.5	-
<b>Бусад татвар /телбэр хураамж/</b>	800.5	1050.5	250.0
Татварын бус орлого	372.0	372.0	

Сангийн яамнаас хянасан 2018 оны суурь орлогын төлөвлөгөөг 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлснийг нэр төрлөөр нь авч үзвэл: Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 30.0 сая, газрын төлбөрийг 5.0 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 10.0 сая, нэр заагдаж ангилагдаагүй бусад орлогыг 192.0 сая, хог хаягдлын үйлчилгээний үйлчилгээний хураамжийн 8.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, бусад татварын орлогыг СЯ-ны хянасан сууриар баталжээ.

Хүснэгт-3 /мян - төгрөгөөр/

Сумдын орон нутгийн орлогын 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, 2018 оны төлөвлөгөө						
Д.д	Сумын нэрс	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	2018 оны төлөвлөгөө	Төлөвлөгөөнөөс зөрүү	Гүйцэтгэлээс зөрүү
1	Алдархаан	108280	103956.8	107060	-1220	3103.2
2	Асгат	86370	90711	78490	-7880	-12221
3	Баянтэс	141495	132905.8	136550	-4945	3644.2
4	Баянхайрхан	114160	117211.1	109220	-4940	-7991.1
5	Тосонцэнгэл	658230	780345.5	678910	20680	-101435.5
6	Дөрвөлжин	493140	928068.6	692850	199710	-235218.6
7	Завханмандал	113920	99646.6	116150	2230	16503.4
8	Идэр	151855	152935.8	147080	-4775	-5855.8
9	Их-уул	229640	353443.3	231600	1960	-121843.3
10	Нөмрөг	111848	139009.3	119300	7452	-19709.3
11	Отгон	110310	120836.2	123270	12960	2433.8
12	Сантмаргац	109578	114545.8	127180	17602	12634.2

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

13	Сонгино	153870	162746.7	162200	8330	-546.7
14	Түдэвтэй	128936	133960.4	145500	16564	11539.6
15	Тэс	310591	313652.6	323000	12409	9347.4
16	Тэлмэн	132695	149869.8	143910	11215	-5959.8
17	Ургамал	106858	138013.1	113910	7052	-24103.1
18	Улиастай	3445096.9	4455842.1	3654585.1	209488.2	-801257
19	Цагаанхайрхан	92088	99164.2	102560	10472	3395.8
20	Цагаанчулуут	95400	88461.4	101630	6230	13168.6
21	Цэцэн-уул	112475	117010.7	114710	2235	-2300.7
22	Шүлүүстэй	109780	137030.5	108630	-1150	-28400.5
23	Эрдэнэхайрхан	272798	304441.8	121360	-151438	-183081.8
24	Яруу	118430	103894.9	112860	-5570	8965.1
25	<b>Сумын дүн</b>	<b>7507843.9</b>	<b>9337704</b>	<b>7872515.1</b>	<b>364671.2</b>	<b>-1465189</b>

2017 оны төлөвлөгөөнөөс 364.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь дараах 2 үзүүлэлттэй холбоотой байна. Үүнд: Дөрвөлжин сумын усны төлбөрийн орлогыг 199.7 сая төгрөгөөр / Баян-айраг эксплорэшин ХХК –аас орох усны орлого/, Улиастай сумын цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 209.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна./ өндөр албан тушаалтны цалингаас хадгаламжийн хүүгийн орлогын нөлөөллийг тооцсон

2017 оны гүйцэтгэлээс 1465.1 сая төгрөгөөр бууруулан батласныг нягтлахад: татварын буцаан олголт, ноосны урамшуулал, үл хөдлөх хөрөнгийн торгууль, төрийн албан хаагч нарын урамшуулал зэрэг нэг удаагийн орлогуудыг хасч тооцоолсон байна.

**Дээрхи төсвийн төсөөлөл, төсөл тооцооллуудыг нягталж үзэхэд 2018 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг харьцангуй бодитой төлөвлөгдсөн гэж дүгнэх үндэстэй байна.**

УИХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар аймгийн 2018 оны төсвийн суурь зарлагыг 20161,3 сая төгрөг, ОНХС-аас санхүүжих суурь зарлага 320.8 сая төгрөг нийт 20482.1 сая төгрөгөөр батлагдсан байна.

Хүснэгт-4 /сая төгрөгөөр/

Төсвийн зарлагын 2018-2020 оны төлөвлөгөөний төсөл, батлагдсан төсөв							
д/д	Байгууллагын нэр	2018 батлагдсан хязгаар	2018 ТШЗ Байгууллагын санал	2019 ТЭЗ төсөл	2020 ТЭЗ төсөл	2018 СЯ Хянаж баталсан	2018 оны ИТХ-аар батлагдсан төсөв
1	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	112.2	500.2	500.2	500.2	164.1	476.2
2	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	881.7	1,474.7	1,467.6	1,472.9	936.3	941.2
3	Аймаг, нийслэлийн иргэдийн Засаг даргын тамгын газар	1,158.1	1,509.6	1,509.5	1,509.5	4,013.6	4,440.8
4	Сум, дүүргийн иргэдийн Засаг даргын Тамгын газар	5,425.8	7,844.5	7,284.1	7,290.5	5,831.2	5,838.9
5	Орон нутгийг өмчийн газар	44.3	135.1	135.1	135.1	48.7	111.8
6	Мал эмнэлэгийн үйлчилгээ	277.4	568.8	568.8	568.8	277.4	277.7
7	Замын сан	227.2	227.2	227.2	227.2	182.4	182.4
8	Ойн анги	57.8	137.9	137.9	137.9	69.1	90.6
9	Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	622.1	819.6	782.9	782.9	747.3	742.1

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

10	Хот тохижуулах газар	129.8	660.1	660.1	660.1	269.5	549.8
11	Аймгийн халамжийн сан	6,995.6	7,858.9	7,859.3	7,859.3	7,761.2	6,940.5
12	Ахмадын хороо	71.5	127.1	119.5	119.5	71.7	56.7
13	Жолоочийн хариуцлагын даатгал	20.3	20.3	23.0	23.0	20.3	20.3
14	Санхүүгийн хяналт аудитын алба	86.9	161.9	161.9	161.9	89.3	136.1
	<b>Дүн</b>	<b>16,110.7</b>	<b>22,045.9</b>	<b>21,437.1</b>	<b>21,448.8</b>	<b>20,482.1</b>	<b>20,805.1</b>

Харин аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний 30 дугаар тогтоолоор 20805.1 сая төгрөгөөр баталсан байна.Үүнд:

Орон нутгийн татварын орлогыг 7042.5 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэг нь 13131.0 сая төгрөгөөр, ОНХС-аас санхүүжих суурь зарлагыг 320.8 сая төгрөгөөр, орон нутгийн татварын орлогыг 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 60.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталжээ.

Хүснэгт -5 /сая төгрөгөөр/

### Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ны өдрийн хуралдааны 30 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн татварын орлого болон төсвийн дэмжлэгийн жагсаалт/ байгууллагууд-

Д.Д	Байгууллагын нэр	2018 оны төсвийн төсөл	2018 оны батлагдсан төсөв	Үүнээс:				
				санхүүгийн дэмжлэг	Татварын орлого	ОНХСа нгаас	Төсөвт байгууллагын өөрийн орлого	Татварын давсан орлого
1	АЗДТГ	1,509.5	4,440.8	4,424.2			16.6	
2	АИТХ	500.2	476.2	476.2				
3	ХТҮА	660.1	549.8	356.7		43.1		150
4	ОНӨГазар	135.1	111.8	91.8			20	0
5	БОАЖГазар	819.6	742.1	740.5			1.6	
6	Ойн анги	137.9	90.6	68.2			22.4	
7	СХДААлба	161.9	136.1	136.1				
8	Халамжийн сан	7,859.9	6,940.5	1,550.2	5,290.3			100
9	Мал эмнэлэг үйлчилгээний хөлс	568.4	277.7	-		277.7		
10	Замын сан	227.2	182.4	182.4				
11	Жолоочийн хариуцлагын даатгал	20.3	20.3	20.3				
12	Ахмадын хороо	127.1	56.7	56.7				
	<b>Нийт дүн</b>	<b>12,727.2</b>	<b>14,025.0</b>	<b>8,103.3</b>	<b>5,290.3</b>	<b>320.8</b>	<b>60.6</b>	<b>250.0</b>

Төсвийн зарлагыг батлахдаа орон нутгийн татварын орлогыг 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь аймгийн Хот тохижилт үйлчилгээний албаны төсвийн зарлагыг 150.0 сая төгрөгөөр, халамжийн санг 100.0 сая төгрөгөөр тус тус нэмж баталсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын баталсан төлөвлөгөөг хянаж үзэхэд халамжийн сангийн зарлагыг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан мөртлөө байгууллагуудын төсвийг батлахдаа халамжийн сангийн Сангийн яамны хянаж баталсан төлөвлөгөөнөөс 820.7 сая төгрөгийг дараахь байдлаар гүйлгэн баталжээ.

Хүснэгт-6/сая төг-р/

**2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт**

д/д	Байгууллагын нэр	2018 СЯ Хянаж баталсан	2018 оны ИТХ-аар батлагдсан төсөв	Зөрүү
1	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	164.1	476.2	312.10
2	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	936.3	941.2	4.90
3	Аймаг, нийслэлийн иргэдийн Засаг даргын тамгын газар	4,013.6	4,440.8	427.20
4	Сум, дүүргийн иргэдийн Засаг даргын Тамгын газар	5,831.2	5,838.9	7.70
5	Орон нутгийг өмчийн газар	48.7	111.8	63.10
6	Мал эмнэлэгийн үйлчилгээ	277.4	277.7	0.30
7	Замын сан	182.4	182.4	-
8	Ойн анги	69.1	90.6	21.50
9	Аймгийн байгаль орчныг хамгаалах газар	747.3	742.1	(5.20)
10	Хот тохижуулах газар	269.5	549.8	280.30
11	Аймгийн халамжийн сан	7,761.2	6,940.5	(820.70)
12	Ахмадын хороо	71.7	56.7	(15.00)
13	Жолоочийн хариуцлагын даатгал	20.3	20.3	-
14	Санхүүгийн хяналт аудитын алба	89.3	136.1	46.80
	<b>Дүн</b>	<b>20,482.1</b>	<b>20,805.1</b>	<b>323.00</b>

Дээрхи шалтгаан нь орон тоог илүү ажиллуулж байгаатай холбоотойгоор гүйлгэн баталсан байна.

Хүснэгт -7 /сая –төгрөгөөр/

2018 оны батлагдсан орон тоо				
д/д	Байгууллагын нэр	Орон тоо		
		Сангийн яамнаас баталсан	ИТХ-аас баталсан	Зөрүү
1	Аймгийн ЗДТГ	61	61	0
2	Аймгийн ИТХ	7	12	-5
3	Сумдын ЗТДГ	549	549	0
4	Сумдын ИТХ	49	49	0
5	Хот Тохижилт Үйлчилгээний Алба	25	48	-23
6	Орон нутгийн өмчийн газар	7	11	-4
7	БОАЖГазар	61	61	0
8	Ойн анги /Түдэвтэй/	3	3	0
9	Ойн анги /Тосонцэнгэл/	3	5	-2
10	Санхүүгийн Дотоод алба	6	10	-4

Аудитын явцад нутгийн захиргааны 36 байгууллагаас аймгийн төвөөс алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан тооцсон төсвийн төсөөллийн тооцооллыг шалгаж үзэхэд сумдууд 28.7-169.4 сая төгрөгөөр харин Улиастай сум 411.0 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс илүү төлөвлөсөн байна. Зардлуудыг нягталж үзэхэд:

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

- Улс төрийн албан тушаалтнуудын цалингийн сүлжээг хамгийн дээд хязгаараар төлөвлөсөн
- Тэтгэвэрт гарах хүмүүсийн нэг удаагийн тэтгэмжийг 18-24 сараар тооцсон
- Сумдын Засаг дарга, багийн засаг дарга нарт нууцын нэмэгдлийг 40%-иар тооцсон
- Улиастай сум болон зарим сумд орон тоо нэмэхээр илүү төлөвлөлт хийсэн
- Тэтгэмж урамшууллын зардлыг бүх байгууллагууд өндөр төлөвлөсөн
- Тавилга эд хогшил, урсгал засварын зардлууд дээр өндөр төсөөллүүд тавьж өгсөн
- Зарим сумд төвлөрсөн халаалтанд холбогдоно гэж халаалтын зардлыг өндөр төлөвлөсөн

Хүснэгт 8/ сая төгрөгөөр/

### Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ны өдрийн хуралдааны 30 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн татварын орлого болон төсвийн дэмжлэгийн жагсаалт /сумдаар//

Д.д	Сумдын нэр	2018 оны төсөл	Үүнээс		
			2018 оны батлагдсан төсөв	санхүүгийн дэмжлэг	Татварын орлого
1	Алдархаан	394.6	278.2	250.1	28.1
2	Асгат	353.8	242.6	223.2	19.4
3	Баянтэс	395.3	278.2	249.3	28.9
4	Баянхайрхан	349.4	228.4	193.2	35.2
5	Дөрвөлжин	360.9	258.3	204.3	54.0
6	Завханмандал	435.4	240.1	209.3	30.8
7	Идэр	310.9	264.5	201.8	59.0
8	Их-Уул	376.3	309.9	233.7	76.2
9	Нөмрөг	322.0	259.5	222.0	37.5
10	Отгон	307.4	270.5	235.3	35.2
11	Сантмаргаз	322.5	259.2	215.6	43.6
12	Сонгино	329.2	257.4	212.4	45.0
13	Тосонцэнгэл	434.8	343.8	196.8	150.0
14	Түдэвтэй	345.8	317.1	267.2	49.9
15	Тэс	393.3	267.0	217.0	50.0
16	Тэлмэн	318.6	250.5	206.8	43.7
17	Ургамал	361.5	249.6	215.7	33.9
18	Улиастай	1,088.7	677.7	-	745.1
19	Цагаанхайрхан	291.6	231.5	198.3	33.2
20	Цагаанчулуут	267.9	227.3	178.9	48.4
21	Цэцэн-Уул	426.8	268.2	256.6	11.6
22	Шилүүстэй	425.0	255.6	231.4	24.2
23	Эрдэнэхайрхан	349.2	270.3	230.7	39.6
24	Яруу	358.1	274.7	245.5	29.2
	<b>Дүн</b>	<b>9,319.0</b>	<b>6,780.1</b>	<b>5,027.7</b>	<b>1,751.7</b>

Орон нутгийн байгууллагуудын төсвийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын СЯ-ны сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг баримтлан боловсруулсан байна.

**Төсвийн байгууллагууд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын эх үүсвэрүүд бага орлого төлөвлөөгүй байна**

**Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөлтийн талаар :**

/Хүснэгт-9-сая-төг-р/

2018 оны өөрийн орлогын төлөвлөлт			
Байгууллагын нэр	д/д	Байгууллагын нэр	

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

Д/Д		Төсөвт байгууллагын өөрийн орлого		Төсөвт байгууллагын өөрийн орлого	
1	Аймгийн ЗДТГ	16.6	5	ЧЭЦСургууль	45.8
2	ОНӨГазар	20	6	ЖЦСургууль	38.0
3	БОАЖГазар	1.6	7	Дэвшил сургууль	50.4
4	Ойн анги	22.4	8	Хүүхдийн 7-р цэцэрлэг	7.64
	<b>Орон нутаг дүн</b>	<b>60.6</b>	9	23 сумын Соёл	42.3
			10	Хөгжим бүжгийн театр	29.7
			11	Орон нутгийг судлах музей	1.95
			12	Биеэн тамир спорт хороо	5.1
				<b>Тусгай шилжүүлгийн байгууллагуудын дүн</b>	<b>220.89</b>

2018 оны өөрийн орлогын төлөвлөгөөг хянаж үзэхэд орон нутгаас 60.6 сая төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагуудаас 220.8 сая төгрөгийг оруулахаар төлөвлөсний 42.3 сая төгрөг нь сумдын соёлын байгууллагуудын өөрийн орлого, 134.2 сая төгрөг нь цогцолбор сургуулиудын өөрийн орлогууд эзэлж байна.

Тус аймагт ТӨҮГ-1, ОНӨҮГ-4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өөрийн орлогын төлөвлөлтийн талаар судалж үзэхэд өмнөх жилүүдийн төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна. Төлөвлөсөн орлогын төлөвлөгөө нь тогтмол бөгөөд хэлбэлзэл бага Завхан АЗЗА ХХК-ын орлого нь улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх замын болон зам засварын орлогоор, Очир-Илч ОНӨААҮГ-нь наймаачдын вандангийн түрээсийн орлогоор, “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ нь айл өрх, албан байгууллагуудын усны орлогоос бүрдэж байгаа бөгөөд бусад чиглэлээр төлөвлөсөн орлого байхгүй байна.

Дээрхи байгууллагуудаас бусад төсвийн байгууллагууд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого олох эх үүсвэрүүд бага орлого төлөвлөөгүй байна

**ЕБС, СӨБ-ийн 2018 оны төсөв бодит байдалтай уялдаагүй СЯ-ны хянасан төсөвт баригдсан хүрэлцээ муутай төсөв батлагдсан байна.**

### Ерөнхий зүйл

ЕБСургуулиуд, СӨБ-ийн 2018 оны төсвийг 2017-2018 оны хичээлийн жилийн суралцагчдын тооны прогноз, 2016 оны жилийн эцсийн хүн амын статистик тоог суурь үзүүлэлт болгон тооцохдоо МУ-ын Засгийн газрын “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжих аргачлал батлах тухай” 2016 оны 242 дугаар тогтоолын дагуу тооцсон байна.

Багш ажилтнуудын үр дүн, урамшуулал олгохтой холбогдон гарсан Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 1а/12347 хамтарсан сайдын тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 346 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолуудын урамшуулал олгох тушаал тогтоолууд төсөл батлуулахад нөлөөлөхгүй хэрэгжилт байхгүй байна.

СЯ багш ажилтнуудад олгох үр дүнгийн болон урамшуулалт цалинг 5-11%- иар тооцож баталдаг бусад бараа үйлчилгээний зардлыг 24-70% хүртэл бууруулан баталж байгаа учраас орон нутгаас төлөвлөж байгаа төсвийн төлөвлөлтийн үр дүн, ач холбогдол харагдахгүй байна.

**Ерөнхий Боловсролын сургуулиуд**



## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

2018 оны төсөв нь 2018 оны төсвийн саналаас 4061.3 сая төгрөгөөр буурч батлагдсаныг гол нэр төрлийн зардлуудаар авч үзэхэд: цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 4622.7 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 78.5 сая төгрөгөөр, бараа үйчилгээний бусад зардлыг 80.0 сая төгрөгөөр тус тус бууруулан батлагдаж харин тогтмол зардлууд нийт дүнгээрээ 357.3 сая төгрөгөөр, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 138.5 сая төгрөгөөр, шагнал урамшуулал 472.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэн батлагдаж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж 573.3 сая төгрөгөөр төсөвлөсөн хэмжээгээр батлагджээ.

2018 оны төсөв нь төсвийн төсөөллөөс буурсан шалтгаан нь:

- Багш ажилчдын ур чадварын нэмэгдлийг сар бүр 25%-иар олгохоор
- Үр дүнгийн урамшууллыг сар бүр 20%-иар олгохоор тооцож төсөөлсөн нь 5-11%-хүртэл буурснаас шалтгаалсан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хянасан 2018 оны төсөв нь 2017 оны ХБГ-ээс 701.4 сая төгрөгөөр нэмэгдсэн эерэг үзүүлэлт харагдаж байгаа боловч дутагдалтай төсөв батлагдсан байна. Үүнд:

Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал нийт дүнгээрээ 177.5 сая төгрөгөөр хасагдаж батлагдсан, үр дүнгийн урамшуулал, гэрээт ажилтнуудын цалинг хасч үндсэн цалинг 852.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь тоо чанарын хувьд ялгаа байхгүй зөвхөн цалингийн зардлуудын нэр төрөл дотор гүйлгэн баталсан төсөв болсон байна гэж дүгнэлээ

Тогтмол зардлыг 759.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталснаас гэрэл цахилгааны зардлыг 65.7 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 728.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, цэвэр бохир усны зардлыг 34.7 сая төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардлыг 28.7-105.5 сая төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

Хоол хүнсний зардлыг 265.4 сая төгрөгөөр, үдийн цайны зардлыг 122.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь бусад бараа үйлчилгээний зардлыг гүйлгэн батлахад хүргэсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний 30 дугаар тогтоолоор СЯ-ны хянасан 2018 оны төсвийг үндсэн үйл ажиллагааны орлогын 134.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж зарим зардлуудыг гүйлгэн баталжээ. /Хүснэгт- 10/ сая-төг-2/

Д/д	Зардлын төрөл	Аймгийн ИТХ-аар нэмэгдүүлэн баталсан орлого	СЯ -ийн хянасан төсвөөс гүйлгэн хасч баталсан мөнгөн дүн /мян-төгрөгөөр/	Аймгийн ИТХ-аар гүйлгэн нэмж баталсан зардал /мян-төг-р/
1	Үндсэн, туслах үйл ажиллагааны орлогоор	134.2		
2	Үндсэн цалингаас		651.6	
3	Гэрэл цахилгаан		53.7	
4	Түлш халаалт		389.8	
5	Хоол хүнсний		238.2	
6	Дүн	134.2	1333.4	
7	Нэмэгдэл цалин			1.8
8	Гэрээт ажилчдын цалин			404.4
9	Үр дүнгийн урамшуулал			608.6
10	НДШ			44.1
11	Бичиг хэрэг			62.2

12	Тээвэр шатахуун		43.2
13	Шуудан холбоо		9.3
14	Ном хэвлэл авах		15.9
15	БҮТЭЭ		4.2
16	Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл		3.0
17	Нормын хувцас		4.9
18	Урсгал засвар		96.6
19	Дотоод албан томилолт		27.9
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		55.5
21	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		66.1
22	Цэвэр бохир ус		19.8
	Дүн		<b>1467.6</b>

Батлагдсан төсөв нь дутагдалтай гэж үзэж байна. Тухайлбал: аймгийн 6 сумын ЕБС нэгдсэн халаалтанд холбогдсон байхад бүх сумын ЕБС-ийг халаалтанд холбогдсоноор гэрэл цахилгаан, түлш халаалтын зардлыг 443.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж нөгөө талаас гэрээт ажилчдын цалингийн 404.3 сая төгрөгийг хасч, хоол хүнсний зардлыг 238.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан зэрэг нь бусад бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэн гүйлгэн батлах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг гүйлгэн баталсан ч цалингийн зардал орон тоо хэвээр ажиллаж байгаа тул аймгийн ИТХ-ын 30 дугаар тогтоолоор 363.1 сая төгрөгөөр бусад бараа үйлчилгээний зардлаас гүйлгэн нэмэгдүүлэн баталжээ.

Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 138.5 сая төгрөгөөр нэмэгдэж орж ирсэн нь өмнөх онд боловсролын салбарт олон жил ажилласан үйлчилгээний ажилтнуудын тэтгэмж олгох сарыг дутуу тооцсон зөрүү нэмэгдэж ирсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд ЕБС-ийн 2018 оны төсөв бодит байдалтай уялдаагүй СЯ-ны хянасан суурь зардлын төсөвт баригдсан хүрэлцээ муутай төсөв батлагдсан гэж дүгнэж байна.

### СӨБ –ийн байгууллагууд

**Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмжийн нийт 301.9 сая төгрөгийн төсөв нь 2018 оны СӨБ-үүдийн төсвийг нэмэгдсэн үзүүлэлтэй харагдуулж байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хянасан 2018 оны төсөв нь 2017 оны ХБГ-ээс 572.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байгаа боловч . Үүнд:

- Багш, ажилтнуудын шагнал урамшуулал 192.6 сая төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 162.7 сая төгрөг, хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж 299.0 сая төгрөг нийт 461.7 сая төгрөгийг тэтгэмж эзэлж байна.
- Үндсэн цалинг 194.7 сая төгрөгөөр, гэрээт ажилчдын цалинг 189.2 сая төгрөгөөр хасч харин нэмэгдэл цалинг 447.9 сая төгрөгөөр, үр дүнгийн урамшууллыг 40.1 сая



төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд тус зардал нийт дүнгээрээ 104.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж батлагдсан байна

Дээрх зардлуудыг хянахад цалингийн зардлууд хоорондоо гүйгдсэн, орон тоо хасагдсан, нэмэгдсэн зүйл байхгүй байна.

- Гэрэл цахилгааны зардал 39.1 сая төгрөгөөр өсч, цэвэр бохир усны зардал 45.1 сая төгрөгөөр буурсан,
- Хоол хүнсний зардлыг 94.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж бусад бараа үйлчилгээний зардал хасагджээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хянасан СӨБ-ийн байгууллагуудын 2018 оны төсөв нь 2018 оны төсвийн саналаас 2106.9 сая төгрөгөөр хасагдаж батлагджээ. Үүнд дараах зүйлүүд нөлөөлжээ Үүнд:

- Багш ажилчдын ур чадварын нэмэгдлийг сар бүр 25%-иар олгохоор
- Үр дүнгийн урамшууллыг сар бүр 20%-иар олгохоор тооцож 5-11% олгохоор баталсан нь нөлөөлжээ

Аудитын явцад сумдын алслалт, хүүхдийн тоог харгалзан 6-8 цэцэрлэгийн төсвийн мэдэгдэл, нийт СӨБ-үүдийн төслийн тооцоог түүвэрчлэн шалгаж үзэхэд тогтмол зардлууд, ажилтнуудын шагнал урамшуулал, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмжүүд тооцооллын дагуу батлагдаж ирсэн байна.

Сум, аймгийн цэцэрлэгүүдийн нэгжээс тооцоолон нэгтгүүлсэн төсөв үр дүн бага СЯ-ны хянасан суурь зарлагаар батлагдаж байгаа нь бодит байдалтай уялдахгүй байна.

### Соёлын байгууллагууд

**Соёлын байгууллагуудын төсөв хийхтэй холбогдуулан гарсан заавар журам байхгүйгээс Соёлын байгууллагуудын төсөв хасагдаж батлагдаж байна.**

23 сумын Соёлын байгууллагуудын 2018 оны батлагдсан төсвийг 2017 оны ХБГ-тэй харьцуулахад 151.2 сая төгрөгөөр бууруулан баталсан нь үндсэн цалинг 10.8 сая төгрөгөөр, гэрээтүүд болон галч нарын цалинг 18.7 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 66.1 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 23.9 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 64.5 сая төгрөгөөр буюу 66.1% иар хасч хянасан байна.

Дээрх байдал нь бодит байдалтай нийцэхгүй, дараахь байдлууд ажиглагдаж байна.

- Соёлын байгууллагууд нь сүүлийн жилүүдэд Соёл Спорт аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, БСШУСЯамдын харъяалалд байсан бөгөөд байгууллагуудын үйл ажиллагаа, төсвийн хууваарилалтанд тавих мэргэжилтэнгүүдийн анхаарал, хяналт суларсан байдал төсөв бодит байдлаар батлагдахад сөргөөр нөлөөлсөн гэж үзэх үндэстэй байна. Жишээ нь:
- Тосонцэнгэл, Алдархаан сумдын соёлын төвүүдээс бусад соёлын байгууллагууд нь нэгдсэн халаалтанд холбогдоогүй байхад галч гэрээт ажилчдын цалинг 100% хассан, түлш халаалтын зардлыг хасч баталсан нь соёлын үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байна,

- Мөн гэрээт болон галч нарын орон тоог 2017 оны гүйцэтгэлээс 13 орон тоогоор бууруулж баталсан нь энгийн галлагаатай соёлын төвүүд үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болсон байна,

Дээрх нөхцлүүдийг харгалзан судалж аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний 30 дугаар тогтоолоор төсвийг батлахдаа 139 орон тоог хэвээр нь ажиллуулж дутагдаж байгаа цалингийн эх үүсвэрийн 141.9 сая төгрөгийг гэрэл цахилгаан, түлш халаалтын зардлаас гүйлгэн зарцуулахаар баталсан байна.

Батлагдсан төсвийг 2018 оны төсвийн төсөөлөлтэй харьцуулахад нийт дүнгээрээ 737.8 сая төгрөгөөр буурч батлагдсан бөгөөд цалин болон НДШ –ийн зардал 416.4 сая төгрөгөөр, тогтмол зардал 114.9 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 84.8 сая төгрөгөөр, урсгал засварын зардал 90.9 сая төгрөгөөр бусад зардлууд 30.8 сая төгрөгөөр тус тус хасагдсан нь төсөөллийг бууруулан төлөвлөсөн нь харагдаж байна.

Аудитын явцад 2018 оны төсвийн төсөөлөл хийсэн байдалд дүн шинжилгээ хийхэд нарийвчилсан тооцоо судалгаа, аргачлал байхгүй өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна. Цалин урамшуулал 50%, бараа үйлчилгээний зардлыг 27%, урсгал засварын зардлыг 9 дахин нэмэгдүүлэхээр /10478.6-96500.0/ төсөөлжээ. Дараах анхаарах асуудлууд байна гэж үзлээ.

- Соёлын байгууллагуудын төсөв хийхтэй холбогдуулан гарсан заавар журам байхгүй,
- Сумын соёлын төвүүд нэгдсэн халаалтанд ортол зайлшгүй гэрээт болон галчийн орон тоо шаардлагатай,
- Мөн бодлогоор соёлын төвүүдийн өөрийн орлого олох эх үүсвэр болон үйл ажиллагааг дэмжих шаардлагатай болсон байна.

ХЖТ, Биеийн тамир спорт хороо 2018 оны төсвийн төсөөлөлд дүн шинжилгээ хийхэд бүх байгууллагууд цалингийн санг өндөр, орон тоо нэмэхээр төсөөлсөн байна.

Аймгийн Биеийн тамир спорт хороо 2018 оны төсвийн төсөөллийг 1501.9 сая төгрөгөөр төсөөлсөн боловч 625.3 сая төгрөгөөр төсөв батлагдсан байна.

2018 онд шинээр “Спорт цогцолбор усан бассей”-н барилга ашиглалтанд орж бүрэн хүчин чадлаар ажиллахад 60 хүний орон тоо шаардлагатай байгаа бөгөөд 2018 оны төсвийн төсөлд 48 орон тоо ажиллуулхаар төлөвлөсөн бөгөөд 15 орон тоо батлагдаж ирсэн нь үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болж байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний 30 дугаар тогтоолоор төсвийг батлахдаа тогтмол зардлаас 102.5 сая төгрөгийг цалингийн зардалд 40.5 сая төгрөг, урсгал зардалд 28.0 сая төгрөг, албан томилолт, зочид буудлын зардалд 10.0 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 18.5 сая төгрөг, бусад төлбөр хураамжийн зардалд 5.5 сая төгрөгийг гүйлгэн зарцуулахаар баталжээ.

Цаашид “Спорт цогцолбор усан бассей”-г бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, сургагч багш нарыг бэлтгэх, өөрийн орлогыг бүрдүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах нь төсөв батлахад нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Сангийн яам улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд 2018 онд шинээр ашиглалтанд орж байгаа “Спорт цогцолбор усан бассей”-н барилгын үйл ажиллагааг судалж үзэлгүй төсвийг баталсан нь төсөв бодитой батлагдаж чадаагүй гэж дүгнэх үндэстэй байна.

Цаашид СЯ орон нутгийн байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийг хянаж батлахдаа тухайн жилд ашиглалтанд орох барилга байгууламжийг судалж үзэх шаардлагатай байна.

**Сумдын эрүүл мэндийн төв**

**Сангийн яам эмч ажилтнуудын урамшууллыг 7-8%-иар тооцож баталсан нь төсвийн төсөл буурах гол үзүүлэлт болж байна.**

СЯ-ны баталсан төсвийг Эрүүл мэндийн яам өөрийн харъяаны Эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилалтийг хийсэн байна.

Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн төсөв нь салбарын батлагдсан төсөвт “Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг” нэршилтэй жилийн дүнгээр аймгийн ТЕЗ-ийн тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсөвт зардлын зүйл ангиар тусгагдан ирснийг Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэнд, Спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 498/345 дугаар тушаалаар батлагдсан “сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг тооцох, хуваарилах аргачлал”-ын дагуу тооцсон төсвийн хуваарийг хийж аймгийн ИТХ-аар оруулан батлуулж хуваарилж байна.

Сумдын төсвийн хуваарийг хийхдээ сумын хүн амын тоо, газар нутгийн алслалт, тухайн сумын үйлчлэх хүрээний радиусаас хамааруулан тооцон гаргаж тогтмол зардал болон бусад зардлыг нэмж төсвийн хуваарилалтыг хийсэн байна.

Хүснэгт-11 /сая -төг-өөр/

<b>Сумдын ЭМТ-ийн 2018 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв</b>		
<b>Байгууллагын нэр</b>	<b>Байгууллагаас ирүүлсэн 2018 оны төсвийн төслийн санал /мян,төг/</b>	<b>Батлагдсан төсөв 2018 он</b>
Алдархаан ЭМТ	342.13	280.27
Асгат ЭМТ	310.66	209.65
Баянтэс ЭМТ	443.83	281.55
Баянхайрхан ЭМТ	234.00	236.37
Дөрвөлжин ЭМТ	438.00	280.15
Идэр ЭМТ	312.20	273.15
Их-Уул ЭМТ	450.74	402.81
Нөмрөг ЭМТ	269.56	237.82
Отгон ЭМТ	467.85	283.61
Сантмаргац ЭМТ	265.69	236.39
Сонгино ЭМТ	273.56	234.08
Тэлмэн ЭМТ	339.37	273.13
Тэс ЭМТ	369.50	297.41
Ургамал ЭМТ	257.13	235.18
Цагаанхайрхан ЭМТ	281.86	228.37
Цагаанчулуут ЭМТ	265.69	228.68
Цэцэн-Уул ЭМТ	318.05	240.17
Эрдэнэхайрхан ЭМТ	276.60	235.11

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

<b>Яруу ЭМТ</b>	289.18	233.09
Нийт	<b>6205.59</b>	<b>4927.00</b>

Дээрх сумдын төсвийн төсөл, батлагдсан төсвийг харьцуулан хамгийн өндөр, хамгийн бага төсөвтэй 8 сумын төсвийн тооцооллыг шалгаж үзэхэд тогтмол болон бусад зардлуудын хувьд харьцангуй бодитой тооцоологдсон, харин цалингийн урамшууллын хувьд сар, улирал дутамд 45% тооцон төсөөлөл хийсэн харин СЯ урамшууллыг 7-8% -иар тооцож төсөв баталсан байгаа нь гол зөрүүг илэрхийлж байна.

### Өрхийн эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/474/360 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардлын хэмжээг тогтоосон тарифаар суурин хүн амаар тооцон зөв төлөвлөсөн байна. Хүснэгт-12/ мян-төг-р/

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2016 оны жилийн эцсийн статистик хүн амын тоо, төсвийн төсөл															
№	Өрхийн эмнэлгийн нэр	Нийт хүн амын тоо	Үүнээс		Үүнээс:										
					0-5 нас		6-15 нас		16-49 насны эмэгтэйчүүд		60-аас дээш		Бусад		
			Гэр хороололд	Байшин хороололд	Гэр хороололд	Байшин хороололд	Гэр хороололд	Байшин хороололд	Гэр хороололд	Байшин хороололд	Гэр хороололд	Байшин хороололд	Гэр хороололд	Байшин хороололд	
Тариф					26479.3	23277	11267	10466	12068	12068	16871.5	15270	9665.6	8865	
1	Улиастай	Дөрвөн оноо	5580	5580	0	707		928		1498		370		2077	
2		Биндэргарав	5573	5277	296	699	50	888	51	1123	76	362	9	2205	110
3		Богд-Өлзий	4603	4390	213	649	30	814	45	1443	39	339	10	1145	89
		Дүн	15756	15247	509	2055	80	2630	96	4064	115	1071	19	5427	199
4	Тосонцэнгэл	Мөнхийн алба	9047	9047	0	1278		1670		2321		616		3162	
5		Дүн	9047	9047	0	1278	0	1670	0	2321	0	616	0	3162	0
<b>Нийт хүн амын тоо</b>			<b>24803</b>	<b>24294</b>	<b>509</b>	<b>3333</b>	<b>80</b>	<b>4300</b>	<b>96</b>	<b>6385</b>	<b>115</b>	<b>1687</b>	<b>19</b>	<b>8589</b>	<b>199</b>
Нийт санхүүжилт			331543.8	325234.9	6308.9	88255.5	1862.1	48447.7	1004.8	77051.6	1387.8	28462.2	290.1	83017.8	1764.1

2018 оны төсвийн төслийг явуулахдаа Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2015 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 14/77 тушаалаар тооцон явуулсан дүн 331.5 сая төгрөг бөгөөд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/474/360 дугаар тушаал төсвийн төслөөс хойш гарч санхүүжилт 347.6 сая төгрөгөөр батлагдан ирсэн байна.

2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн төсөл болон батлагдсан төсөв			
Өрхийн эмнэлгийн нэр	Өрхийн ЭМТ-үүдээс ирүүлсэн санал /сая-төг/	ЭМЯ-нд хүргүүлсэн төсөл /сая -төг/	2018 оны батлагдсан төсөв /сая -төг/
Өрхийн ЭМТийн төвүүд /4/	445.4	331.5	347.6

Өрхийн эмнэлгүүдийн суурин хүн амаар тооцсон төсөв нь харьцангуй бодитой хийгдэх боломжтой ажиглагдаж байгаа бөгөөд 2016 оны жилийн эцсийн суурин хүн амын статистикаар гарсан тоонд тооцжээ

**Бүлэг -2**

**2.1.2018 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө бүрэн хэрэгжих боломжтой байна.**

**Татварын орлогын гүйцэтгэлийн талаар:**

Орон нутгийн татварын орлого 9 сарын 30-ны мэдээгээр 6121.8 сая төгрөг буюу 113%-иар биелэгдсэн бөгөөд сумдын орлогоос түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.3%-ийн биелэлттэй, 3 нэр төрлийн татварын орлого 61.4-72.6%-тай бусад нэр төрлийн татварууд 99.1-261.6%-ийн биелэлттэй байна.

Аймагт төвлөрүүлэх татварын орлогоос 3 нэр төрлийн татвар 76.8-97.3%-ийн биелэлттэй бусад татварууд 112.1-160.2%-ийн биелэлттэй байна./хүснэгт-13 сая -төг-2/

2018 оны орон нутгийн төсвийн орлогын төвлөрүүлэлтийн мэдээ							
Татварын төрөл	2018 оны төлөвлөгөө	2018 оны 09 сарын төлөвлөгөө /ессөнөөр/	2018 оны 09 сарын гүйцэтгэл /ессөнөөр/	2018.09.30			
				Биелэлтийн хувь-/9 сар/	ХБГ	ХБГ нийт зөрүү	
ХХОАТ	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос	419.2	332.4	397.8	119.7	424.6	5.40
	Үйл ажиллагааны орлогын албан татвар	130.0	87.0	62.3	71.6	80.2	(49.80)
	Иргэдийн хадгаламжийн хүүгийг орлого	460.8	338.7	649.9	191.8	710.0	249.20
	Галт зэвсгийн албан татвар	49.5	28.9	21.0	72.6	41.4	(8.10)
	<b>Дйн</b>	<b>1,059.5</b>	<b>787.1</b>	<b>1,130.9</b>	143.7	<b>1,256.2</b>	196.70
	Улсын тэмдэгтийн хураамж	67.8	46.5	65.5	140.8	72.1	4.29
	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	6.0	4.4	6.0	137.0	6.8	0.79
	Ойн нөөц ашигласны төлбөр	110.0	67.4	141.9	210.6	164.0	54.00
	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	-	99.0	#DIV/0!	99.0	99.02
	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	6.5	4.8	6.0	126.4	6.5	-
Бусад татвар	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15.0	11.3	0.7	6.3	15.0	-
	Хог хаягдлын йлчилгээний хураамж	100.0	60.0	76.7	127.8	100.0	-
	<b>Дйн</b>	<b>305.3</b>	<b>194.4</b>	<b>395.9</b>	203.6	<b>463.4</b>	158.10
	Хтй торгуулийн орлого	30.9	18.3	47.8	261.6	50.0	19.12

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

Аймгийн төсвийн орлого	Нэр заагдаагүй бусад орлого	166.9	78.9	48.4	61.4	102.0	(64.92)
	<b>Дйн</b>	<b>197.8</b>	<b>97.1</b>	<b>96.2</b>	<b>99.1</b>	<b>152.0</b>	<b>(45.80)</b>
	<b>Сумын төсвийн орлогын дйн</b>	<b>1,562.6</b>	<b>1,078.6</b>	<b>1,623.0</b>	<b>150.5</b>	<b>1,871.6</b>	309.00
	Цалин хөлс, тийнтэй адилтгах бусад орлого	5,257.5	3,500.0	3,404.4	97.3	5,154.3	(103.22)
	Ўл хөдлөх хөрөнгийн татвар	125.0	77.4	173.7	224.4	194.0	69.00
	АТБСЯХ-ийн албан татвар	265.0	237.3	266.0	112.1	270.1	5.12
	Улсын тэмдэгтийн хураамж	129.2	88.0	105.5	119.9	120.4	(8.76)
	Усны нөөц ашигласны төлбөр	224.0	157.7	201.9	128.1	228.6	4.61
	Газрын төлбөр	195.0	131.4	128.7	98.0	187.2	(7.80)
	Хтй торгуулийн орлого	29.1	18.6	14.3	76.8	24.7	(4.39)
Нэр заагдаагүй бусад орлого	335.1	127.5	204.3	160.2	341.0	5.92	
<b>Аймгийн төсвийн орлогын дйн</b>	<b>6,559.9</b>	<b>4,337.8</b>	<b>4,498.8</b>	<b>103.7</b>	<b>6,520.4</b>	<b>(39.51)</b>	
<b>Орон нутгийн төсвийн орлогын дйн</b>	<b>8,122.5</b>	<b>5,416.4</b>	<b>6,121.8</b>	<b>113.0</b>	<b>8,392.0</b>	269.49	

### Давсан орлогын талаар

- *Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 311.1 сая төгрөгөөр давж биелсэн нь 2017.05.01-ээс хууль хэрэгжиж эхэлсэн /ХХОАТ-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-р заалт/*
- *Ойн нөөц ашигласны төлбөр хураамжийн орлого 74.4 сая төгрөгөөр давж биелсэн нь ой модтой сумдын ойн цэвэрлэгээний модны төлбөрөөр*
- *Ул хөдлөх хөрөнгийн татвар 96.20 сая төгрөгөөр давж биелсэн нь Баян-айраг Эксплорейшн компанийн үл хөдлөх хөрөнгийн татвар /сендэвчин барилга/*
- *Нэр заагдаагүй бусад орлого 76.8 сая төгрөгөөр давж биелсэн нь Төрийн аудитын газрын 21.4 сая төгрөг, Цагдаагийн газрын 131.4 сая төгрөг, Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 61.8 сая төгрөг, МХГ-ын актын төлбөр 23.0 сая төгрөгийн төлбөрийн актууд барагдсантай тус тус холбоотой байна*
- *Ан амьтны нөөц ашигласны төлбөр 99.0 сая төгрөг төлөвлөгөөгүйгээр орсон*

### Тасарсан орлогын талаар

- *Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр батлагдсан төлөвлөгөө 15.0 сая төгрөг хэдий ч 0.7 сая төгрөг төвлөрсөн байгаа нь байгаль орчны улсын байцаагчдын ажил үүрэгтэй холбоотой шахалт шаардлага суларсантай холбоотой байна.*
- *Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, суутгаагчийн хувь хүнд олгосон орлогын татвар 95.6 сая төгрөгөөр тасарсан мэдээтэй байгаа нь /ХХОАТ-хуулийн 23.1 заалт хүчингүй болсонтой уялдаж байна./*



## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

*Татварын орлогыг ХБГ-ээр авч үзэхэд 8392.0 сая төгрөг төвлөрч 269.5 сая төгрөгөөр давж биелэх тооцоо мэдээ гарсан нь батлагдсан төлөвлөгөө 100% биелэх боломж харагдаж байгаагаас 2018 оны татварын орлогын төлөвлөгөө бодитой төлөвдөгдсөн гэж үзэж байна.*

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 9 сарын байдлаар төлөвлөгөө 93.7% -иар тасарч байгаад анхаарч ажиллан аймагт баригдаж байгаа барилга байгууламж, хөрөнгө оруулалтын ажлуудын судалгааг гаргах, элс хайрга буталж байгаа компаниудын орлогыг тооцон үзэж татварын төлөвлөгөөг биелүүлэх шаардлагатай байна.

Мөн цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлогын төлөвлөгөө тасарч байгаа мэдээтэй ч оны эцсээр Төрийн албан хаагч нарын цалин хөлсийг 8% нэмэгдүүлсэнтэй холбогдон давах магадлалтай байна.

Аудитын явцад ТЕЗ-ийн байгууллагуудын 9 сарын 1-ээс нэмэгдүүлсэн цалинг урамшуулалтай зэрэгцүүлэн дүгнэлт хийж орлого нэмэгдэх боломж байгааг тооцлоо. Үүнд: .....

*Сумдын татварын орлогыг авч үздэл 83.4-166.3%-тай төвлөрсөн дүнтэй байна.  
Хүснэгт-14/ сая -төг-өөр/*

Д.д	Сумын нэрс	2018 оны Төлөвлөгөө	2018 оны 09 сарын 30-ны байдлаарх төлөвлөгөө	2018 оны 09 сарын 30-ны байдлаарх гүйцэтгэл	Хувь	ХБГ	Хувь
1	Алдархаан	107.1	76.4	85.4	111.7	116.0	108.4
2	Асгат	78.5	56.8	55.3	97.4	80.1	102.1
3	Баянтэс	136.6	95.2	90.1	94.7	131.5	96.3
4	Баянхайрхан	109.2	76.9	73.2	95.2	112.3	102.8
5	Тосонцэнгэл	678.9	467.1	555.0	118.8	766.8	112.9
6	Дөрвөлжин	692.9	518.9	639.9	123.3	734.3	106.0
7	Завханмандал	116.2	82.9	73.6	88.8	106.8	92.0
8	Идэр	147.1	103.8	113.5	109.3	156.8	106.6
9	Их-уул	231.6	168.2	178.6	106.2	242.0	104.5
10	Нөмрөг	119.3	86.1	83.4	96.8	124.6	104.5
11	Отгон	123.3	91.6	76.6	83.6	114.7	93.1
12	Сантмаргац	127.2	93.7	91.8	98.0	127.8	100.5
13	Сонгино	162.2	108.9	99.9	91.7	153.2	94.4
14	Түдэвтэй	145.5	104.0	89.8	86.3	131.3	90.2
15	Тэс	323.0	229.4	191.4	83.5	285.1	88.3
16	Тэлмэн	143.9	104.7	96.0	91.7	135.3	94.0
17	Ургамал	113.9	81.1	75.5	93.2	108.4	95.2
18	Улиастай	3654.6	2394.7	2897.7	121.0	4075.6	111.5
19	Цагаанхайрхан	102.6	72.3	63.0	87.2	93.3	90.9
20	Цагаанчулуут	101.6	70.4	68.3	97.0	101.8	100.1
21	Цэцэн-уул	114.7	84.7	72.2	85.3	102.3	89.1
22	Шүлүүстэй	108.6	76.4	127.0	166.4	120.3	110.8
23	Эрдэнэхайрхан	121.4	90.3	129.7	143.6	146.1	120.4
24	Яруу	112.9	82.1	94.9	115.6	125.6	111.3
	Сутын дүн	<b>7872.5</b>	<b>5416.4</b>	<b>6121.8</b>	<b>113.0</b>	<b>8392.0</b>	<b>106.6</b>

*Сумдын орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө жилийн эцэст бүрэн биелэх боломж харагдаж байна. Энэ нь төлөвлөлт бодитой хийгдсэн гэж дүгнэх байна.*

**2.2. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор орлого нэмэгдүүлэх боломж бага байна.**

## Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт -15 /сая.төг-өөр/

Орлого, зардлын нэр төрөл	2018 оны төлөвлөгөө	9 сарын төлөвлөгөө	9 сарын гүйцэтгэл	хувь
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого	220.8	164.6	206.3	125.3
Орон нутгийн байгууллагуудын өөрийн орлого	60.6	59.6	65.7	110
Амь-Ус ХХК	688.4	481.8	491.1	101.9
Очир-Илч ОНӨҮГ	180.0	90.0	92.5	102.8
Завхан АЗЗА ТӨҮГ	991.4	800.0	793.1	99.1
Тосон очир хайрхан ОНӨҮГ	546.8	352.7	267.1	75.7
Хүмүүний амьдрах ухаан	-	-	-	
Шинэ- Дөрвөлжин ОНӨҮГ	-	-	6.0	
<b>Дүн</b>	<b>2,141.2</b>	<b>1,596.0</b>	<b>1,988.1</b>	

Дээрх байдлаас дүгнэхэд математикийн гүнзгийрүүлсэн Дэвшил ЕБС болон Б.Элдэв-очирын нэрэмжит ЧЭҮЛС, ЖЦС-иудын хувьд анги дэвшсэн хүүхдийн тооноос шалтгаалан орлого нэмэгдэх боломж байгаа ч төлбөрөөс чөлөөлөгдөх дараах шалтгаануудаас хамааран төлөвлөсөн хэмжээнд орлого орж байна.

- ✓ Бүтэн болон хагас өнчин хүүхдүүд
- ✓ Сургалтын амжилт ахиц гаргасан
- ✓ Улсын болон аймгийн олимпиад, тэмцээнд түрүүлсэн
- ✓ Нэг өрхөөс 3 хүүхэд сурч байгаа бол 1 хүүхдийг чөлөөлөх
- ✓ Амжиргааны доод түвшингээс доогуур орлоготой
- ✓ Шилжилт хөдөлгөөн

Аудитын явцад төсөвт байгуулалгуудын орлогыг судалж үзэхэд орлого нэмэгдэх боломжууд бага дээрх сургуулиудын мөрдөж байгаа “сургалтын нэмэгдэл зардал, зардлыг хүлээж авах, зарцуулахдаа баримталж байгаа” БСШУ-ны сайдын 2002 оны 333 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам” нь хот болон хөдөө орон нутагт нэг хүүхдээс авах төлбөрийн доод болон дээд хэмжээг тогтоож өгөөгүй байна.

Сургуулиуд хамт олны хурлаар төлбөрийг нэмэх хасахыг тогтоодог бөгөөд төлбөр тогтооход барих жишиг байхгүйгээс өндөр тогтоовол эцэг, эхчүүд сурагчид төлж чадахгүй он дамжих авлага үүсэх эрсдлүүд үүсч болзошгүй байна.

Тиймээс хот болон хөдөө орон нутагт нэг хүүхдээс авах төлбөрийн доод болон дээд хэмжээг тогтоож өгөх шаардлагатай байна гэж үзлээ.

Аудитын явцад төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор орлого нэмэгдүүлэх боломж байгаа эсэх талаар судалж үзэхэд боломж муу байна.

Харин математикийн гүнзгийрүүлсэн Дэвшил ЕБС болон Б.Элдэв-очирын нэрэмжит ЧЭҮЛС, ЖЦС-иудын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2018-2019 оны хичээлийн жилийн бодит хүүхдийн тоотой тулган баталгаажуулахад зөрүүтэй байгааг тооцон үр өгөөж тооцлоо.



ЖЦС-ийн хувьд 2018 оноос өөрийн харъяаны “Өргөө” амралтын үндсэн үйл ажиллагааны орлого, цайны газруудын орлогыг төлөвлөгөөнд тусгах, орлого нэмж оруулах талаар зөв бодлого явуулах талаар зөвлөмж өгч, үр өгөөж тооцлоо.

**Бүлэг.3 Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн цалингийн нэмэгдлээр тусгай шилжүүлгийн байгууллагуудад 808.6 сая төгрөгийн цалингийн сан дутагдаж өр үүсэх магадлалтай байна.**

**3.1 Орон нутгийн байгууллагуудын төсөв батлагдсан хэмжээнд зарцуулагдсан бөгөөд үүссэн өглөгүүд барагдах боломжтой байна.**

ТЕЗ-ийн 2018 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийг 9 дүгээр сарын 30-ны байдлаар тасалбар болгон мэдээг авлаа. 9 сарын байдлаар 47,388.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 885.1 сая төгрөгийн өглөгтэй 3104.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн дансан дахь үлдэгдэлтэй мэдээ гарсан байна.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН 9 САРЫН 30-НААР		Хүснэгт -16 /сая.төг-өөр/		
үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
0102 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,348.97	47,388.46	5,960.51	88.83
0103 НИЙТ ЗАРЛАГА	52,256.81	46,572.50	5,684.31	89.12
0104 УРСГАЛ ЗАРДАЛ	46,838.89	42,210.82	4,628.07	90.12
0105 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,173.52	31,974.09	2,199.43	93.56
<b>0106 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	21,880.24	21,371.15	509.09	97.67
0107 Үндсэн цалин	16,485.30	16,569.03	(83.73)	100.51
0108 Нэмэгдэл	3,440.91	3,123.12	317.79	90.76
0110 Урамшуулал	966.21	806.62	159.60	83.48
0111 Гэрээт ажлын хөлс	987.82	872.38	115.44	88.31
0112 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,626.15	2,551.61	74.54	97.16
0113 Тэтгэврийн даатгал	1,750.76	1,929.13	(178.37)	110.19
0114 Тэтгэмжийн даатгал	218.84	154.79	64.05	70.73
0115 ҮОМШӨ-ний даатгал	175.08	119.62	55.46	68.32
0116 Ажилгүйдлийн даатгал	43.77	33.29	10.48	76.06
0117 Эрүүл мэндийн даатгал	437.70	314.77	122.93	71.91
0118 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,755.72	3,047.84	707.87	81.15
0119 Гэрэл, цахилгаан	364.73	250.35	114.38	68.64
0120 Түлш, халаалт	3,209.79	2,679.94	529.85	83.49
0121 Цэвэр, бохир ус	181.20	111.31	69.89	61.43

2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

0122	Байрны түрээс	-	6.25	-	-
				(6.25)	
0123	Хангамж, бараа материалын зардал	957.90	817.24	140.66	85.32
0124	Бичиг хэрэг	126.42	104.55	21.87	82.70
0125	Тээвэр, шатахуун	556.53	516.90	39.63	92.88
0126	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	104.06	79.84	24.22	76.72
0127	Ном, хэвлэл	28.74	17.78	10.97	61.85
0128	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55.74	22.83	32.91	40.96
0129	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн	86.41	75.35	11.06	87.20
	эд зүйлс				
0130	Нормативт зардал	1,849.15	1,399.93	449.22	75.71
0131	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177.12	176.51	0.61	99.66
0132	Хоол, хүнс	1,539.72	1,143.09	396.62	74.24
0133	Нормын хувцас, зөөлөн эдлэл	132.32	80.33	51.99	60.71
0134	Эд хогшил, урсгал засварын зардал	373.54	320.70	52.84	85.85
0135	Багаж, техник, хэрэгсэл	31.43	17.08	14.34	54.36
0136	Тавилга	3.50	-	3.50	-
0138	Урсгал засвар	338.61	303.61	34.99	89.67
0139	Томилолт, зочны зардал	168.43	137.26	31.17	81.49
0141	Дотоод албан томилолт	168.43	137.26	31.17	81.49
0143	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	966.61	841.30	125.31	87.04
0144	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	935.86	821.88	113.97	87.82
0145	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	12.94	7.27	5.67	56.18
	тогтоох				
0146	Даатгалын үйлчилгээ	7.92	6.75	1.18	85.13
0147	Тээврийн хэрэгслийн татвар	6.52	4.03	2.49	61.77
0148	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.21	0.61	0.60	50.13
0149	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1.70	0.62	1.08	36.32
0150	Газрын төлбөр	0.45	0.15	0.30	33.42
0153	Бараа үйлчилгээний бусад зардал	1,576.65	1,468.18	108.48	93.12
0154	Бараа үйлчилгээний бусад зардал	1,314.48	1,268.36	46.13	96.49
0155	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	262.17	199.82	62.35	76.22
0162	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>12,669.31</b>	<b>10,240.42</b>	<b>2,428.89</b>	<b>80.83</b>
0166	Бусад урсгал шилжүүлэг	7,694.17	6,265.00	1,429.17	81.43
0170	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	465.62	405.44	60.18	87.08

**2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт**

0168	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,344.60	4,735.81	608.79	88.61
0172	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	967.51	748.85	218.67	77.40
0173	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх д	820.94	321.15	499.79	39.12
0174	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	95.51	53.76	41.75	56.29
0163	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,975.14	3,975.42	999.72	79.91
0164	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,975.14	3,975.42	999.72	79.91
0159	ТАТААС	<b>15.20</b>	<b>15.20</b>	-	<b>100.00</b>
0161	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	15.20	15.20	-	100.00
0175	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	5,417.92	4,361.68	1,056.24	80.50
0179	Бусад хөрөнгө	5,417.92	4,361.68	1,056.24	80.50
0181	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	1,092.16	812.81	279.35	74.42
0182	Эргэж төлөгдөх зээл	1,092.16	815.96	276.20	74.71
0185	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,290.47	50,493.2	3,965.58	92.56
0186	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	27,723.27	26,927.5	795.74	97.13
0189	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	27,723.27	26,927.5	795.74	97.13
0191	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	<b>23,629.83</b>	20,972.9	<b>2,605.03</b>	<b>88.98</b>
0192	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,005.13	18,524.7	2,480.44	88.19
0193	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,521.70	2,448.2	73.46	97.09
0198	ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ	<b>2,137.37</b>	2,592.7	<b>615.94</b>	<b>71.18</b>
0199	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	615.21	1,391.0	(775.74)	226.10
0201	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,400.66	1,201.8	271.41	80.62
0205	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,104.70	-	-

Нийт 22 хөтөлбөр арга хэмжээгээр төсвийн гүйцэтгэлийг гаргасан бөгөөд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 9185.9 сая төгрөгийг, тусгай зориулалтын шилжүүлгээр 26927.5 сая төгрөгийг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2448.2 сая төгрөгийг, орон нутгийн татварын орлогоор 9338.7 сая төгрөг, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 1391.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 1201.8 сая төгрөгийн нийт 50493.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 47388.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг Хөтөлбөр арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:

<b>Хөтөлбөр арга хэмжээгээр гаргасан 9 сарын 30-наарх төсвийн гүйцэтгэл</b>						
						Хүснэгт- 17 сая төг-р
д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өр төлбөр	Бодит гүйцэтгэл	Зөрүү

## 2018 оны төсвийн тухай хуулийн явцын хэрэгжилт

1	Мэргэжлийн хяналт	103.1	103.1		103.08	-0.04
2	Хот байгуулалт, тохижилт	414.1	360.1	39.9	400.04	-14.02
3	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	573.8	560.4	11.1	571.46	-2.35
4	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	15.2	15.2		15.20	0.00
5	Мал аж ахуйг хөгжүүлэх	275.0	274.5		274.52	-0.48
6	Авто зам	160.0	130.0		130.00	-30.00
7	Ахмад настны хөгжил хамгаалал	58.5	58.5		58.50	0.00
8	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	89.1	82.0	4.5	86.46	-2.61
9	Газрын зураглал, кадастр	330.4	317.4		317.41	-12.95
10	Нийгмийн эрүүл мэнд	356.5	281.3		281.35	-75.18
11	Хүүхдийн хөгжил, хамгаалал	135.1	124.5	13.6	138.12	3.02
12	Нийгмийн халамж	5,404.0	4,752.7		4752.73	-651.27
13	Ойжуулалт	80.5	68.6		68.61	-11.90
14	ЗДТГ	10,821.0	9,418.4	136.1	9554.53	-1266.42
15	ИТХ	1,116.7	1,049.7	16.8	1066.49	-50.24
16	ЕБСургууль -1	15,121.0	13,734.5	331.3	14065.83	-1055.20
17	сургууль -2	75.1	61.7		61.75	-13.40
18	цэцэрлэг	6,305.5	5,699.0	124.2	5823.21	-482.28
19	Соёл урлаг	1,739.0	1,623.2	149.5	1772.66	33.62
20	Эмнэлэг	3,825.2	3,625.9	58.1	3683.97	-141.26
21	ОНХС	5,257.9	4,231.7		4231.68	-1026.24
22	СХС	1,092.2	816.0		815.96	-276.20
	Дүн	53,349.0	47,388.5	885.1	48273.56	-5075.41

### Орон нутгийн байгууллагууд

Орон нутгийн байгууллагууд 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 20485.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 17945.5 сая төгрөгийг зарцуулж 208.4 сая төгрөгийн өрийг нэмж тооцвол 18153.9 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 9 сарын мэдээгээр 2332.0 сая төгрөгийн хэмнэлтэй, 237.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 2651.3 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна.

ИТХ-ын байгууллагууд 9 сарын мэдээгээр 1116.7 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1049.6 сая төгрөгийг зарцуулсан 16.8 сая төгрөгийн өрийг нэмж тооцвол 1066.5 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 50.3 сая төгрөгийн хэмнэлттэй, 27.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 334.2 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-1/

9 дүгээр сарын гүйцэтгэлээр тэтгэврийн даатгал 11.2 сая төгрөгөөр хэтэрсэн мэдээтэй бусад зардал төлөвлөсөн хэмжээнд байна.

Өглөгийн хувьд дүн шинжилгээ хийвэл цалин, НДШ-ийн 14.0 сая төгрөгийн өглөг, 2.8 сая төгрөгийн бусад бараа үйлчилгээний зардлуудын өглөг эзэлж байна.

Аймгийн болон сумдын ЗДТГ-ууд 9 сарын мэдээгээр 10820.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 9418.4 сая төгрөгийг зарцуулсан 136.1 сая төгрөгийн өрийг нэмж тооцвол 9554.6 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 1266.4 төгрөгийн хэмнэлттэй, 209.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 861.4 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-2/

Өглөгийн хувьд цалин, тэтгэвэрийн даатгалын 38.8 сая төгрөг, тогтмол зардлын 19.3 сая төгрөгийн ,тээвэр шатахууны 43.7 сая төгрөгийн бусад бараа үйлчилгээний 34.3 сая төгрөгийн өглөгүүд үүссэн байна.

Зардлуудын хэтрэлтийг тооцоход үндсэн цалин 67.4 сая төгрөг, тэтгэвэрийн даатгал 22.9 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй бусад зардлуудын хувьд хэмнэсэн мэдээ гарсан байна.

Дээрх байдлуудаас дүгнэхэд аймгийн болон сумдын ЗДТГ-уудын төсөв батлагдсан хэмжээнд зарцуулагдах боломжтой, үүссэн өглөгүүд нь дараа саруудын хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй холбоотой байгаа тул барагдах боломжтой гэж дүгнэлээ.

Бусад орон нутгийн байгууллагууд батлагдсан сар улирлын төлөвлөгөөний дагуу зарцуулагдсан байна

Засгийн газрын 2018 оны 9 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр төсөвлөсөн урамшууллын дүнг зэрэгцүүлэн тооцоолсноор ИТХ-ын байгууллагуудын цалин 2.8 сая төгрөгийн урамшууллын дутуу, ЗДТГ-ууд 2.4 сая төгрөгийн цалингийн илүү, бусад байгууллагууд 4.4 сая төгрөгийн илүү нийт 6.8 сая төгрөгийн урамшуулалт цалингийн сан илүү төлөвлөгдсөн тооцоо гарч байна.

Орон нутгийн байгууллагуудын цалингийн нэмэгдлээр оны эцэст өглөг үүсэхээргүй байна гэж үзлээ.

Орон нутгийн байгууллагуудын төсөв зориулалтын дагуу төлөвлөсөн сар улирлын дагуу лимитээр зарцуулагдаж байна.

**Тусгай шилжүүлгийн байгууллагуудад Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр төсөвлөсөн урамшууллын дүнг хасч тооцоолсноор 808.1 сая төгрөгийн цалингийн сангийн өр үүсэх тооцоолол гарч байна.**

Нийт тусгай шилжүүлгийн байгууллагуудын 9 сарын мэдээгээрх нийт өглөг 663.1 сая төгрөг мэдээлэгдсэн нь оны эцэст барагдах боломжтой гэж үзлээ.

Харин Засгийн газрын 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр төсөвлөсөн урамшууллын дүнг хасч тооцоолсноор 808.1 сая төгрөгийн цалингийн сангийн өр үүсэх тооцоолол гарч байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын 9 сарын мэдээгээр төсвийг зориулалтын дагуу зарцуулсан гэж дүгнэлээ.

## ЕБС

**ЕБС**-иудын хөтөлбөр арга хэмжээгээр гарсан 9 сарын төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд 15196.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 13796.2 сая төгрөгийг зарцуулж 331.3 сая төгрөгийн өр байгааг нэмж тооцвол 14127.5 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 9 сарын мэдээгээр 1068.5 сая төгрөгийн хэмнэлтэй, 798.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 7567,7 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-3/

Гүйцэтгэлийг ХБГ-тэй харьцуулбал бүх зардал хэмнэлттэй, харин 9 дүгээр сарын гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 128.1 сая төгрөгөөр, тэтгэв рийн даатгал 190.6 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 21.4 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн мэдээ гарчээ.

Нийт өглөгийн хувьд дүн шинжилгээ хийвэл цалингийн, НДШ-ийн 157.5 сая төгрөг, тогтмол зардал 40.9 сая төгрөгийг эзэлж байгаа бөгөөд 132.9 сая төгрөг нь бусад бараа үйлчилгээний зардлуудын өглөг эзэлж байна.

Дээрх өглөгүүд нь хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй холбоотой учир урьдчилан дүгнэх боломжгүй байна.

Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр нийт 1090.5 сая төгрөгийн тооцоолол гарч байгаа бөгөөд төсөвт урамшууллын зардалд 486.3 сая төгрөг батлагдсан бөгөөд 604.2 сая төгрөгийн цалингийн сан дутагдаж өр үүсэх эрсдэл байна.

Зардлын хэмнэлт хэтрэлт нь 9 сарын байдлаар дээрх 3 зардлаас бусад нь хэмнэсэн дүнтэй байгаа бөгөөд зардал нэг бүрийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллавал өргүй гарах боломж харагдаж байгаа бөгөөд төсвийн жил дуусаагүй байгаа тул урьдчилан дүгнэлт өгөх боломжгүй байна гэж үзлээ.

## СӨБ

**СӨБ**--ийн байгууллагуудын хөтөлбөр арга хэмжээгээр гарсан 9 сарын төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд 6305.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 5699.0 сая төгрөгийг зарцуулж 124.2 сая төгрөгийн өр байгааг нэмж тооцвол 5823.2 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 9 сарын мэдээгээр 482.3 сая төгрөгийн хэмнэлтэй, 424.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 2797.7 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-4/

Гүйцэтгэлийг ХБГ-тэй харьцуулбал бүх зардал хэмнэлттэй, харин 9 дүгээр сарын гүйцэтгэлээр, тэтгэвэрийн даатгал 67.1 сая төгрөгөөр, урсгал засварын зардал 7.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн мэдээ гарчээ.

Нийт өглөгийн хувьд цалингийн, НДШ-ийн 41.3 сая төгрөг, тогтмол зардал 10.3 сая төгрөг, хоол хүнсний зардал 55.3 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардлууд 17.3 сая төгрөгийг эзэлж байна.

Хоолны зардал нь 9 сарын хоолны санхүүжилт хасагдаж ирсэнтэй холбоотой бусад өглөгүүд нь хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй холбоотой учир урьдчилан дүгнэх боломжгүй байна.

Засгийн газрын 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр нийт 335.4 сая төгрөгийн тооцоолол гарч байгаа бөгөөд төсөвт урамшууллын зардалд 191.1 сая төгрөг батлагдсан бөгөөд 144.3 сая төгрөгийн цалингийн сан дутагдаж өр үүсэх магадлал байна.

## СОЁЛ

**СОЁЛ** -ийн байгууллагуудын хөтөлбөр арга хэмжээгээр гарсан 9 сарын төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд 1739.0 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1623.2 сая төгрөгийг зарцуулж 149.5 сая төгрөгийн өр байгааг нэмж тооцвол 1772.6 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 9 сарын мэдээгээр 33.6 сая төгрөгийн зардлын хэтрэлттэй, 104.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 1310.9 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-5/

Гүйцэтгэлийг ХБГ-тэй харьцуулбал бүх зардал хэмнэлттэй харин 9 дүгээр сарын гүйцэтгэлээр тэтгэвэрийн даатгал 4.2 сая төгрөгөөр, түлш халаалтын зардал 102.4 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн мэдээ гарчээ.



Нийт өглөгийн хувьд цалингийн, НДШ-ийн 10.3 сая төгрөг, түлш халаалтын зардлын 136.9 сая төгрөгийн өрийн 90%-ийг Тосонцэнгэл, Алдархаан сумдын халаалтын зардал эзэлж байна.

Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор цалинг 30%-хүртэл нэмсэн бөгөөд цалингийн нэмэгдлээр нийт батлагдсан цалингаас 110.2 сая төгрөгийн тооцоолол гарч байгаа бөгөөд төсөвт урамшууллын зардалд 61.8 сая төгрөг батлагдсан бөгөөд 48.4 сая төгрөгийн цалингийн сан дутагдаж өр үүсэх магадалтай байна.

**ЭМТ**

ЭМТ-ийн шилжүүлгийн байгууллагуудын хөтөлбөр арга хэмжээгээр гарсан 9 сарын төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд 3564.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 3365.2 сая төгрөгийг зарцуулж 58.1 сая төгрөгийн өр байгааг нэмж тооцвол 3423.2 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй 9 сарын мэдээгээр 141.3 сая төгрөгийн хэмнэлттэй, 198.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй жилийн дүнгээр тооцвол 1503.8 сая төгрөгийн хүлээгдэж байгаа үлдэгдэлтэй мэдээ гарсан байна./хавсралт-6/

Гүйцэтгэлийг ХБГ- тэй харьцуулбал бүх зардал хэмнэлттэй харин 9 дүгээр сарын гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 52.7 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардал 2.1 сая төгрөгөөр, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардал 40.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн мэдээ гарчээ.

Нийт өглөгийн хувьд дүн шинжилгээ хийвэл цалингийн 5.1 сая төгрөг нь Засгийн газрын 263,264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн нэмэгдэл цалин 9 сарын 1-ээс хэрэгжсэн боловч 10 сард нэмэгдэл санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

Түлш халаалтын зардлын 5.0 сая төгрөгийн өр нь урьдчилан бэлтгэсэн түлээ, нүүрстэй холбоотой бөгөөд санхүүжилтийг 3,4-р улиралд тавьж өгсөн нь өр үүсэхэд нөлөөлсөн байна.

Цаашид жилийн эцэст хэтэрч болзошгүй тээвэр шатахуун, шуудан холбоо, бичиг хэргийн зардлуудад хяналттай ажиллах шаардлагатайгаас гадна төлөвлөгөөгүйгээр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал гаргахгүй байхад анхаарах нь зүйтэй байна.

Засгийн газрын 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлээр нийт 122.3 сая төгрөгийн тооцоолол гарч байгаа бөгөөд төсөвт урамшууллын зардалд 110.7 сая төгрөг батлагдсан бөгөөд 11.6 сая төгрөгийн цалингийн сан дутагдаж байгаа эрсдэл байна.

Өрхийн эмнэлгүүд 347.6 сая төгрөгийн төсвөөс 260.7 сая төгрөгийг зарцуулж 86.9 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

ЭМТ-ийн төсвийн зарцуулалтанд дүгнэлт хийхэд 9 сарын байдлаар үүссэн өр нь барагдах боломжтой, бусад зардлуудын хувьд зориулалтын дагуу зарцуулагдсан байна гэж үзлээ.

**Бүлэг 3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын 24 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчсөн байна.**

А. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хувьд:

Аймгийн ИТХХ-ны 2017 оны 30 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний санхүүжилтийг 1,651.5 сая төгрөгөөр, замын сангийн санхүүжилтийг 182.4 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2,796.9 сая төгрөгөөр тус тус батлан нийт 4,630.8 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтанд зарцуулахаар баталсныг тайлант оны 1, 9 дүгээр саруудад 2 удаа нэмэх зөвшөөрөл олгосноор нийтдээ 4,971.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- ✓ Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 06 дугаар тогтоолоор 9 төсөл арга хэмжээг нэмж 291.0 сая төгрөгийг өмнөх оны татварын давсан орлогоор санхүүжүүлэхээр баталсан
- ✓ Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 48 дугаар тогтоолоор аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 97 арга хэмжээнээс 715.0 сая төгрөгийн санхүүжилттэй хэрэгжээгүй 7 төсөл арга хэмжээг хасч, уг санхүүжилтээр 19 төсөл арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр, 50.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг татварын давсан орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 117 төсөл арга хэмжээний зориулалт, санхүүжүүлэх эх үүсвэрийг авч үзвэл дараахь байдалтай байна.

- Орон нутгийн өмчийн барилга байгууламж бий болгох, их засвар хийхэд 1,309.8 сая төгрөгийн хөрөнгө хуваарилснаас 416.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 100.0 сая төгрөгийг татварын давсан орлогоор, 793.5 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор санхүүжүүлэхээр,
- Орон нутгийн байгууллагуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд 448.4 сая төгрөгийн хөрөнгө хуваарилснаас 34.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 79.0 сая төгрөгийг татварын давсан орлогоор, 335.4 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор санхүүжүүлэхээр,
- Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцсэн бусад арга хэмжээг санхүүжүүлэхэд 1,552.8 сая төгрөгийн хөрөнгө хуваарилснаас 517.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 80.0 сая төгрөгийг татварын давсан орлогоор, 182.4 сая төгрөгийг орон нутгийн замын сангийн хөрөнгөөр, 753.2 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор санхүүжүүлэхээр,
- Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагуудын автомашины парк шинэчлэлд 549.0 сая төгрөгийн хөрөнгө хуваарилсныг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор санхүүжүүлэхээр,



- Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 8 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 392.8 сая төгрөгийн хөрөнгө хуваарилснаас 286.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 40.0 сая төгрөгийг татварын давсан орлогоор, 66.8 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор санхүүжүүлэхээр,
- Сургалт сурталчилгаанд 697.6 сая төгрөгийн хөрөнгө хуваарилснаас 304.1 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын орлогоор, 383.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр, 10.0 сая төгрөгийг татварын давсан орлогоор,
- Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчин Улиастай, Тосонцэнгэл сумдын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлэхэд 20.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Эндээс харахад орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчсөн 403.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн аймгийн ИТХ-аар батлуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих”, 64.2-д “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасныг, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам” зэргийг зөрчсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх барилга байгууламж барих, засварлах ажлууд нь батлагдсан зураг төсөвгүйгээр төлөвлөгдсөн, 70.0 сая төгрөгийн 1 ажлыг зураг төсөвгүйгээр ажлаа эхлүүлсэн, 45.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний зураг төсвийг хянуулаагүй байна.

*Тухайлбал: Улаанхаалгын амралтын зам засварын ажил нь зураг төсөвгүй, Их-Уул сумын хяналтын пост барих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын ажлын зураг, төсөв хянагдаагүй байна.*

Аймгийн Засаг даргад ЗГХЭГ, Хууль зүй дотоод хэргийн, Зам тээврийн хөгжлийн, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын, Эрүүл мэндийн сайд нар хамтран ажиллах гэрээний дагуу 9,941.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах 9 барилга, 9 их засварын ажлыг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

**Шинээр баригдах 2 барилга, 9 их засварын ажлыг батлагдсан зураг төсөвгүй, холбогдох тооцоо судалгаа, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс явуулсан саналыг харгалзаж үзэлгүйгээр салбар яамдын сайд нар төлөвлөж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон, төсөл арга хэмжээг тусгана” гэж заасныг, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам” зэргийг зөрчсөн байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийг 2018 онд хийлгэн ажлыг эхлүүлж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх, гэрээт ажил хугацаандаа хийгдэхгүй байх, засварын ажил чанаргүй хийгдэх эрсдлийг бий

болгож байна. Тухайлбал: Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын зураг төсвийг гүйцэтгэсэн Есөн харш ХХК засварын ажлын зураг төсвийг хянуулаагүйгээс зурагт цахилгааны засварын ажил тусгагдаагүй орхигдсон байна. Гэтэл аймгийн ГХБХБГ хянагдаагүй зураг төсөвтэй ажлыг эхлүүлэн, ашиглалтанд хүлээж авснаар засварын ажил чанаргүй хийгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламж барих засварлах, тоног төхөөрөмж нийлүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцсэн ажлууд нь хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

**Б. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны хувьд:**


Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 50 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байдлыг шалгахад дараахь зөрчил илэрсэн.

- ✓ Их-Уул сумын ЗДТГ-ын барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгохдоо ТБОНӨХБАУХА тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиололд тендерээс татгалзах ёстой”, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д “Захиалагч тендер нээсний дараа тендерийн агуулга, үнийн талаар тендерт оролцогчтой санал солилцохыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөнөөс шалтгаалан гомдол гарч тендер цуцлагджээ.
- ✓ АЗДТГ-ын тавилга худалдан авах ажлын гүйцэтгэгчдээс ирүүлсэн тендерийг хянан үзэхдээ Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ыг зөрчсөнөөс цуцлагдан дахин зарлагджээ.
- ✓ Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлын шууд гэрээ байгуулахдаа гүйцэтгэгч компаний барилга барих тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан байсныг харгалзаж үзээгүй байна.

**В. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн хувьд:**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 94 төсөл арга хэмжээнд 3,287.6 сая төгрөгийг олгосон бөгөөд хэрэгжиж дууссан 5 төсөл арга хэмжээний 124.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй хүлээгдэж байна. Аудитаар орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас санхүүжигдэх 259.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн зөрчил илэрснийг залруулах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт дараахь байдалтай байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан ажлын санхүүжилтийг журмын дагуу олгож байгаа байдал, үр дүн, хэрэгжилтийг шалгахад дараахь зөрчил илэрлээ.

Санхүүжилтийг гэрээний дагуу гүйцэтгэлд үндэслэн олгосон байдлын хувьд:

- ✓ Баруун чиглэлийн авто замуудын гол зангилаа суманд хяналтын пост байгуулах ажлын гүйцэтгэлийн тайлан ирүүлээгүй байхад 13.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон
- ✓ Аймгийн Засаг даргын захирамж, гэрээгүйгээр 5 төсөл арга хэмжээнд 84.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд эдгээрийн гүйцэтгэлийн тайлан ирээгүй байна.
- ✓ Шилүүстэй сумын сум дундын эмнэлгийг мэс заслын тоног төхөөрөмжөөр хангах 50.0 сая төгрөгийн гэрээтэй ажлыг Эрүүл мэндийн яамны 25.0 сая төгрөгийн санхүүжилтээр, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эндээс харахад аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 5.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгогдохоор байгааг залруулах шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн тайлангаа ирүүлээгүй, үр дүнг тооцоогүй төсөл арга хэмжээнүүд:

- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны автомашины шинэчлэлт хийхэд 20.0 сая төгрөгийг олгосон боловч нягтлан бодогч нь сургалтанд явсан гэсэн шалтгаанаар худалдан авалтын болон гүйцэтгэлийн баримтыг ирүүлээгүй байна.
- ✓ Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 69.4 сая төгрөгийг олгосон боловч одоо болтол гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна.
- ✓ Хөрш болон бусад орнуудтай харилцах хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд 60.4 сая төгрөг зарцуулснаас аймгийн ИТХ 1.5 сая төгрөгийн, Солилцооны бирж 34.2 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайланг тус тус ирүүлээгүй,
- ✓ Шилүүстэй сумын сургуулийн талбайг тохижуулахад 10.0 сая төгрөгийг олгосон боловч гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй
- ✓ Улиастай сумын цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр “Амь-Ус трейд” ОНӨААТҮГ-т 33.0 сая төгрөгийг олгосон боловч тухайн чиглэлээр бодитой ажил хийгдээгүй байна.

Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр олон жижиг төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг ирүүлдэггүй, хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний гэрээний үр дүнг дүгнэдэггүй зөрчлийг таслан зогсоох шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж байгаа 18 төсөл арга хэмжээний санхүүжилт 9,941.4 сая төгрөг батлагдсанаас Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсийн конторын барилгын санхүүжилт 1,100.0 сая төгрөгийн эрх шилжиж ирээгүй бөгөөд 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар гүйцэтгэлд үндэслэн 5,145.3

сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Хөрөнгө оруулалтын хэрэгжилт дараахь байдалтай байна.

- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хугацаа алдсанаас шалтгаалан Их-Уул сумын ЗДТГ-ын барилга барих ажил хийгдээгүй,
- Баянхайрхан сумын сургууль, спорт заалны барилга барих, Их-Уул сумын цэцэрлэгийн барилгыг худалдан авах ажил болон 6 их засварын ажлууд хийгдэж дууссан
- 9 хөрөнгө оруулалтын ажил хэрэгжиж байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гэрээний дагуу олгосон байдлыг шалгахад зөрчил илрээгүй.

**Бүлэг 4. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа зарим дэд хөтөлбөрүүдийн суурь болон шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй байна.**

Аймгийн Засаг дарга нь 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 16 дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эдгээр дэд хөтөлбөрөөс доорх 3 дэд хөтөлбөрийг батлуулахаар боловсруулалтын шатанд байна.

- ✓ Аймгийн мал сүргийг эрүүлжүүлэх, чанар шимийг сайжруулах хөтөлбөр
- ✓ Ахмадын сургаал алт хөтөлбөр
- ✓ Нэг өрх нэг ажлын байр хөтөлбөр

Харин 2018 оны 9 дүгээр сард “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байна.

Батлан хэрэгжүүлж буй 13 хөтөлбөрийн чанарын болон тоон үзүүлэлт хэр зохистой байгааг шалгахад дараахь байдалтай байна.

- ✓ “Авилгын эсрэг -Авилгаас ангид”, “Боловсрол, соёлын салбарыг хөгжүүлэх”, “Сайн эмч”, “Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах” зэрэг хөтөлбөрүүдийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой тооцжээ.
- ✓ “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд залуу малчдын зөвлөгөөн зохион байгуулахдаа АНУ, Канад, Баян-Өлгий, Булган, Архангай аймгаас туршлагатай малчдыг урин арга туршлагыг нэвтрүүлсэн, залуу малчин эмэгтэйчүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан зэрэг сайн талууд байна. “Сайн малчин” хөтөлбөр нь 4 үндсэн зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, шалгуур үзүүлэлт нь зорилттойгоо бүрэн уялдаагүй, суурь үзүүлэлтийг тооцоогүй байна.
- ✓ “Сайн багш” хөтөлбөрийн хүрээнд “Багшийн сэтгэл хүүхдэд” сэдэвт 4 удаагийн сургалт зохион байгуулсан, сайн ажиллаж байгаа багш нарыг урамшуулдаг системийг бий болгожээ. Энэ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлтийг бодитой тооцоогүйгээс хяналт үнэлгээ хийхэд хүндрэл учирч байна.
- ✓ “Оюунлаг Завханчууд” хөтөлбөрийн хүрээнд “Гарын 5 хуруу” дуулалт жүжгийг шинээр найруулан тавих, “2000 цэргийн бослого” кино бүтээх зэрэг ажлуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэн, “Жаргалтай гэр бүлийн хөтөч” номыг хэвлүүлэн иргэдэд түгээж, “Бизнес инкубатор” төвтэй гэрээ байгуулан 24 сумдад сургалт

зохион байгуулсан байна. Энэ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлтийг бодитой тооцоогүй байна.

- ✓ “Элэг бүтэн Завхан”, “Эрх зүйн боловсрол-Эрс шинэчлэлт”, “Стандарттай Завхан” зэрэг хөтөлбөрүүд нь үндсэн зорилтын хүрээнд хүрэх үр дүнгээ тодорхойлсон ч шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлтийг бодитой тооцоогүй байна. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд хөрөнгө тусгагдаагүй тул хэрэгжилт хангалтгүй байна.
- ✓ “Эрүүл хүнс-Эрүүл мэнд”, “Сайн бизнесмен” хөтөлбөрүүдэд бодитой хэрэгжих асуудлыг тусгаагүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой төлөвлөөгүй, “Стандарттай Завхан” хөтөлбөртэй уялдаагүй байна.
- ✓ “Сайн оюутан” хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд хэт олон, хоорондоо давхардсан, үр дүнг тооцоход хүндрэлтэй байна.

Цаашид шалгуур болон суурь үзүүлэлтүүдийг бодитой тооцоогүй 9 хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаанд анхааран, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэн, хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Мөн хөтөлбөрт бодитой, хэрэгжих боломжтой асуудлыг төлөвлөн, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн уялдааг сайжруулах шаардлагатай байна.

#### **4.2 Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хөтөлбөрүүдэд 276.0 сая төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулж байна.**

Аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 60.0 сая төгрөгийг, “Сайн эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 60.0 сая төгрөгийг, “Оюунлаг Завханчууд” хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 120.0 сая төгрөгийг, “Сайн оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 40.0 сая төгрөгийг, “Сайн малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 10.0 сая төгрөгийг, “Сайн бизнесмен” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 30.0 сая төгрөгийг, “Хүүхдэд ээлтэй” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 6.0 сая төгрөгийг, “Авлигын эсрэг- Авлигаас ангид” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 3.0 сая төгрөгийг, “Эрүүл хүнс-Эрүүл Завхан” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1.0 сая төгрөгийг, “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”-т 66.8 сая төгрөгийг нийтдээ 396.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

- ✓ “Сайн бизнесмен” хөтөлбөрийн хүрээнд 30.0 сая төгрөгийг “Хамтын хүч - хөгжлийн гарц” аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн, аймаг, бүсийн хилийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад зарцуулжээ. Хэрэгжүүлэгч болон зохион байгуулагч талууд хүрсэн үр дүн, үйл ажиллагааны тайланг ирүүлээгүй байна. Цаашид аймгийн ХАҮТ, аймгийн ХХААЖҮГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай байна.
- ✓ “Сайн багш” хөтөлбөрийн хүрээнд багш нарын сургалт, урамшуулалд 41.4 сая төгрөгийг, “Сайн эмч” хөтөлбөрийн хүрээнд эмч, сувилагч нарын сургалт, урамшуулалд 9.4 сая төгрөгийг, “Сайн оюутан” хөтөлбөрийн хүрээнд урамшуулалд 13.5 сая төгрөгийг, “Сайн малчин” хөтөлбөрийн хүрээнд залуу малчдын сургалт, урамшуулалд 10.0 сая зориулалтын дагуу зарцуулсан байна.
- ✓ “Хүүхдэд ээлтэй”, “Авлигын эсрэг- Авлигаас ангид”, “Эрүүл хүнс-Эрүүл Завхан” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгоогүй байна.
- ✓ “Оюунлаг Завханчууд” хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд математикийн 16 дахь удаагийн наадамд 19.9 сая төгрөгийг, урамшуулалд 2.0 сая төгрөгийг, “Бизнес

инкубатор” төвтэй сургалт явуулах гэрээ байгуулан 30.0 сая төгрөгийг, 13.0 сая төгрөгөөр “Жаргалтай гэр бүлийн хөтөч” ном худалдан авсан, аймгийн ХЖТ-д “Гарын 5 хуруу” дуулалт жүжгийг бүтээхэд 30.0 сая төгрөгийг олгон,”2000 цэргийн бослого” кино бүтээхэд 20.0 сая төгрөгийг, нийт 114.9 сая төгрөгийг зарцуулаад байна. “Бизнес инкубатор” төвөөс сургалтын явцын талаар тайланг ирүүлээгүй байна.

- ✓ “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд 56.8 сая төгрөгийг зарцуулсан боловч гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байна.

#### 4.3 Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийгдэх хуулийн хугацаа болоогүй байна.

2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь аймгийн Засаг даргын хэрэгжүүлж байгаа 13 дэд хөтөлбөрт хяналт үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь хяналт үнэлгээ хийх хуулийн хугацаа болоогүй байгаатай холбоотой байна.

##### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

2017 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэлсэн тайлангаар 2065.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн СХС-ийн зээлийг барагдуулахаар 24 суманд албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг авч үзэхэд 334.1 сая төгрөгийг дансанд төвлөрүүлж, 1016.5 сая төгрөгийг Шүүхийн байгууллагад шилжүүлж 589.3 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гаргуулан, 17.7 сая төгрөгийг хаалгаж, 44.9 сая төгрөгийг хугацаа дууссан гэж буцаасан, 7.0 сая төгрөгөнд эд хөрөнгийн зүйл авчээ. Албан шаардлагын хэрэгжилт 68.8%-тай байна.

Аудитаар 115.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн 3 байгууллагад зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 1,826.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлээ.



**АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. ТЕЗ-ийн төсвийн хүрээний мэдэгдлүүдийн үзүүлэлтүүд нь төсвийн тогтвортой байдлын тухай ,төсвийн тухай хуулийн шаардлагуудад нийцэж байна.
2. Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ны өдрийн хуралдааны 30 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 6267.5 сая, татварын бус орлогыг 372.0 сая, хөрөнгийн албан татвар 439.5 сая, бусад албан татвар 1050.5 сая төгрөгөөр, аймгийн дүнгээр нийт 8129.5 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянаснаас Төрийн аудитын газрын орлого нэмэгдүүлэх саналаар 86.0 сая төгрөг, ИТХ-ын хуралдаанаар 192.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний 30 дугаар тогтоолоор орон нутгийн орлогыг 20805.1 сая төгрөгөөр батлаж, халамжийн сангийн зарлагыг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж,байгууллагуудын төсвийг батлахдаа халамжийн сангийн Сангийн яамны хянаж баталсан төлөвлөгөөнөөс 820.7 сая төгрөгийг орон нутгийн 4 байгууллагад гүйлгэн зарцуулахаар баталжээ.
4. ЕБС, СӨБ-ийн 2018 оны төсөв бодит байдалтай уялдаагүй СЯ-ны хянасан төсөвт баригдсан хүрэлцээ муутай төсөв батлагдсан байна.
5. Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмжийн нийт 301.9 сая төгрөгийн төсөв нь 2018 оны СӨБ-үүдийн төсвийг нэмэгдсэн үзүүлэлтэй харагдуулж байна.
6. Соёлын байгууллагуудын төсөв хийхтэй холбогдуулан гарсан заавар журам байхгүйгээс Соёлын байгууллагуудын төсөв хасагдаж батлагдаж байна.
7. Сангийн яам эмч ажилтнуудын урамшууллыг 7-8%-иар бууруулан тооцож баталсан нь төсвийн төсөл буурах гол үзүүлэлт болж байна.
8. Орон нутгийн татварын орлого 9 сарын 30-ны мэдээгээр 6121.8 сая төгрөг буюу 113%-иар биелэгдсэн бөгөөд сумдын орлогоос түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.3%-ийн биелэлттэй, 3 нэр төрлийн татварын орлого 61.4-72.6%-тай бусад нэр төрлийн татварууд 99.1-261.6%-ийн биелэлттэй байна.
9. Аймагт төвлөрүүлэх татварын орлогоос 3 нэр төрлийн татвар 76.8-97.3%-ийн биелэлтэй бусад татварууд 112.1-160.2%-ийн биелэлттэй байна.
10. Орон нутгийн байгууллагуудын төсөв батлагдсан хэмжээнд зарцуулагдсан, үүссэн өглөгүүд барагдах боломжтой байна.
- 11.Тусгай шилжүүлгийн байгууллагуудад Засгийн газрын 2018 оны оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлийг оруулаагүй төсөвлөсөн урамшууллын дүнг хасч тооцоолсноор 808.1 сая төгрөгийн цалингийн сангийн өр үүсэх тооцоолол гарч байна.
- 12.Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг зөрчсөн 403.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- 13.Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх барилга байгууламж барих, засварлах ажлууд нь батлагдсан зураг төсөвгүйгээр төлөвлөгдсөн, 70.0 сая төгрөгийн 1 ажил зураг төсөвгүйгээр ажлаа эхлүүлсэн, 82.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний зураг төсвийг хянуулаагүй байна.

14. Санхүүжилтийг гэрээний дагуу гүйцэтгэлд үндэслэн олгодоггүй, гүйцэтгэлийн тайлангаа хугацаанд нь авдаггүй, төсөл арга хэмжээний үр дүнг тооцдоггүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.
15. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй 9 дэд хөтөлбөрүүдийн суурь болон шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй, хөтөлбөр хоорондын болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.
16. Орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас санхүүжигдэх 259.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн зөрчил илэрлээ.

ДАРГА,  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Д.Батсайхан,  
аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Ж.Хүрэлбаатар нарт

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэн нэмэлт даалгавар өгч батлахдаа Татварын хэлтэстэй зөвшилцөж, татварын нэр төрлөөр баталж байх,
2. Орон нутгийн татварын орлогын ХБГ-д дүгнэлт хийж төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллахад анхаарах,
3. Тусгай шилжүүлгийн байгууллагуудад Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоолоор нэмсэн 8%-ийн цалингийн нэмэгдлийн дүнгээс төсөвлөсөн урамшууллын дүнг хасч тооцоолсноор 808.1 сая төгрөгийн цалингийн сангийн өр үүсэх тооцоолол гарч байгаад анхаарч ажиллан өр авлага үүсгэхгүй байх,
4. Орон нутгийн байгууллагуудын орон тоог Сангийн яамны хянасан тоонд бариулж илүү орон тоо ажиллуулахгүй, халамжийн сангийн төсвийг бусад байгууллагад гүйлгэн зарцуулахгүй байх,
5. Бараа үйлчилгээний бусад зардал, тээвэр шатахуун, албан томилолт, урсгал засварын зардлуудын зарцуулалтанд хяналттай ажиллаж, батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байх,
6. Соёлын байгууллагуудын төсвийн төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулж, төлөвлөлтийг оновчтой болгох талыг анхааран ажиллах,
7. Орон нутгийн хөгжлийн сангийн журам зөрчсөн төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлдэг байдлыг таслан зогсоох
8. Батлагдсан зураг төсөвтэй төсөл арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байх, тайлант онд зураг төсөвгүйгээр ажлаа эхлүүлсэн, зураг төсвийг хянуулаагүй төсөл арга хэмжээнүүдийн зөрчлийг холбогдох гүйцэтгэгчдээр арилгуулах
9. Орон нутгийн өмчийн газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай бүрэн хэрэгжүүлэх үүргийг хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллах
10. Төсөл арга хэмжээний санхүүжилт олгох, гүйцэтгэл, үр дүнг тооцох ажлыг сайжруулан илэрсэн зөрчлийг арилгах
11. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй 9 дэд хөтөлбөрүүдийн суурь болон шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэнд хяналт үнэлгээг хийх, хөтөлбөр хоорондын болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах

12. Орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас санхүүжигдэх 259.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн зөрчлийг залруулах

Гүйцэтгэлийн аудитаар тогтоогдсон зөрчлийг албан шаардлагаар заасан хугацаанд барагдуулж, өгөгдсөн дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн биелэлтийг 2019 оны 02-р сарын 05-ний дотор албан тоотоор ирүүлэх

ДАРГА,  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

